



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

Аудитын код: БНА-2022/02-НА-СТА

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2022 оны 04 дүгээр сарын 20	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584	Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
	Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424	Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn
	Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99061861	Цахим хаяг: Altantuyam@audit.gov.mn
	Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393	Цахим хаяг: Usukhbayarj@audit.gov.mn
	Аудитор: П.Амаржаргал Утас: 88106992	Цахим хаяг: Amarjargalp@audit.gov.mn
	Аудитор: Л.Доржханд Утас: 99093683	Цахим хаяг: Дorjhandl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Мөнхбат

Аудитын менежер
А.Цээням

Тайланг бэлтгэсэн

Ахлах аудитор
М.Алтантуяа

Аудитор
Л.Доржханд
Ж.Өсөхбаяр
П.Амаржаргал

2022 оны 04 дүгээр
сарын 20-ний өдөр

Уг тайланг УАГ-ын
Цахим хуудаснаас үзнэ үү:
www.audit.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70442424
дугаарын утас, 70442584
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:
Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газар
Аймгийн ЗДТГ-ын байр,
Баянхонгор сум,
Баянхонгор аймаг-64000
Монгол Улс

АГУУЛГА

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ З

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх 3

Аудитын зорилт 3

Аудитын хамарсан хүрээ 3

Аудитын арга зүй 3

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт..... 4

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн 4

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам 4

Хүндрэл бэрхшээл..... 4

Товчилсон үгийн тайлбар 4

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 5

БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ТӨЛӨВЛӨЖ, ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 125.0% БУЮУ 3,454.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА. 6

1.1. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан 13,826.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. 6

1.2. Төлөвлөсөн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 125.0 хувиар биелүүлсэн ч аж ахуйн нэгжүүдээс “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээний дагуу олгосон 3,361.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.11

БҮЛЭГ 2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд нэмж төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан. 17

2.1. ТЕЗ-ийн батлагдсан төсвийг Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин гарсан, ЕБС-ийн урамшууллын зардлыг орон нутагт шилжүүлсэнтэй холбоотойгоор төсвийн жилийн дундуур тодотгол хийж төлөвлөгөөг 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн баталжээ.17

2.2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд зарцуулж Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.19

Бүлэг 3. Сумдын ТТЗ-ийн нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг сумын ИТХ-аар батлуулж тайлагнаагүй, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. 37

АУДИТЫН ДҮГНЭЛТ 41

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ 42

АУДИТЫН ЗОРИЛТ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/11 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын сэдэв батлах тухай”, А/12 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” -г үндэслэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн 2021 оны ТЕЗ-ийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд

- Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх,
- Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 22.2.4¹ дэх хэсэг, 24.5², 24.6³ дахь заалтын дагуу батлуулж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх.
- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төсвийн орлого, зарлагыг зүй зохистой, үр ашигтай байдлаар Төсвийн тухай хуулийн 54.5⁴-т заасан бүрэлдэхүүнээр гарган, хэрэгжүүлж хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтод түвшинд нийцсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Татварын хэлтсийн тайлан, Сангийн яамнаас Баянхонгор аймгийн 2021 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, MNS 6817-4:2020 “Төрийн аудит. Санхүүгийн аудит”, 6817-6 :2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, МУЕА-ын 2021 оны А/71 тушаал “Заавар аргачлал батлах тухай” журмын аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга

¹ 22.2.4.хөтөлбөрөөр

² 24.5.Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон түүний эрхлэх асуудлын хүрээний агентлаг, харьяа байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил, үйлчилгээг тухайн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх аль нэг хөтөлбөрт хамруулсан байна.

³ 24.6.Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ

⁴ Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт

болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Монгол улсын 2021 оны төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Шилэн дансны тухай хууль
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд,
- МУЕА-ын 2021 оны “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай” А/111 тушаал
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Алтантуяа, аудитор Л.Доржханд, Ж.Өсөхбаяр, П.Амаржаргал нар 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 20-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл, хэлэлцүүлсэн журам

Аудитын тайланг үндсэн мэдээлэл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмж гэсэн агуулгаар бичиж, аудитын тайланд аудитын менежер, тэргүүлэх аудитор нараар үе шатны хяналт хийлгэж, тайланг аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн ахлах мэргэжилтэн төсөвт байгууллага, сангийн батлагдсан анхны болон тодотгосон төсвийн хуваарийг эх үүсвэр, зардлын ангиллаар гаргаж, нэгтгэж ирүүлдэггүй, аудитаас шаардсан мэдээ, судалгааг удаа дараа шаардуулж ирүүлдэг, бүрэн гаргаагүй зэрэг нь аудит хийхэд хүндрэл учруулсан болно.

Товчилсон үгийн тайлбар

Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт
 Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
 Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
 Жижиг дунд үйлдвэрлэл
 Засаг даргын Тамгын газар
 Иргэдийн төлөөлөгчдийн хурал
 Орон нутгийн өмч
 Орон нутгийн өмчийн газар
 Орон нутгийн хөгжлийн сан
 Санхүү төрийн сангийн хэлтэс
 Сум хөгжүүлэх сан
 Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгө

АДБООС
 АТӨЯХАТ
 БСШУС
 ЖДҮ
 ЗДТГ
 ИТХ
 ОНӨ
 ОНӨГ
 ОНХС
 СТСХ
 СХС
 ТБОНӨХ

ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦХТАО	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу олгох санхүүгийн дэмжлэг анх 16,240.3 сая, тусгай зориулалтын шилжүүлэг 47,378.9 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг 7,781.6 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг 640.5 сая, нийт 72,041.3 сая төгрөгийн тусламжийн орлого, аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 11,167.9 сая төгрөгийн татварын, 2,037.0 сая төгрөгийн татварын бус орлого, хөрөнгийн орлого 105.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1,937.1 сая, өмнөх оны үлдэгдлээс 3,236.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний өдрийн 2/09 дугаар тогтоолоор 2021 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 90,525.1 сая төгрөгийн төсөв баталснаас хөрөнгийн зардалд 8,853.5 сая төгрөгийг хуваарилсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/10 дугаар тогтоолоор өмнөх оны төсвийн үлдэгдлийг 1143.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,853.3 сая төгрөгөөр, 2021.07.21-ний өдрийн хуралдааны 4/15 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, анхны батлагдсан төсвийг 4,378.7 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлэн нийт 96,047.2 сая төгрөгөөр төсвийг баталж, батлагдсан төсөвт аймгийн Засаг дарга төсөвт зохицуулалт хийх захирамжийг 3 удаа гаргасан байна.

Сумдын ИТХ-ын тогтоолоор 2021 оны орлогыг 8,975.2 сая төгрөгөөр баталснаас татварын орлогыг 3,422.9 сая, хүү торгуулийн орлого 277.3 сая, орон нутгийн байгууллагын өөрийн орлого 74.1 сая, тусгай шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого 13.0 сая, ОНХС-ийн орлогоор 411.2 сая, СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 1,579.6 сая төгрөг оруулж, урьд оны үлдэгдлээс 3,608.3 сая төгрөгөөр тус тус санхүүжихээр баталжээ.

Аймгийн ТЕЗ-ийн дүнгээр дээрх тайланд онд 96,047.2 сая төгрөгийн төсөв батлагдаж 89,196.8 сая зарцуулснаас урсгал зардалд 81,653.4 сая, хөрөнгийн зардалд 7,543.4 сая төгрөг зарцуулсан байна.

АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ТАТВАРЫН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ТУЛГУУРЛАН ТӨЛӨВЛӨЖ, ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ 125.0% БУЮУ 3,454.5 САЯ ТӨГРӨГӨӨР ДАВУУЛАН БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА.

1.1. Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан 13,826.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар Баянхонгор аймгийн Засаг дарга Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгээр 16,240.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 47,378.9 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 7,781.6 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлгийг 640.5 сая, нийт тусламж санхүүжилтийн орлогыг 72,041.3 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн СТСХ-ээс Сангийн яаманд татварын орлогыг 8390.5 сая, хүү, торгуулийн орлогыг 1,000.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 15.0 сая, нийт 9,405.5 сая төгрөгөөр төлөвлөж хүргүүлснийг Сангийн яам татварын орлогыг 10,070.0 сая, хүү торгуулийн орлого болон төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг хэвээр, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 42.7 сая төгрөгөөр баталж, 2021 онд орон нутгийн урсгал орлогоор нийт 11,127.7 сая төгрөгийг оруулахаар хянасан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний өдрийн 2/09 дугаар тогтоол, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор аймгийн төсөвт төвлөрөх татварын орлогыг 11,167.9 сая төгрөгийн татварын, татварын бус орлогыг 2,037.0 сая, санхүүгийн дэмжлэгийг 16,240.3 сая, тусгай зориулалтын шилжүүлгийг 47,378.9 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох дэмжлэг 7,781.6 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг 640.5 сая, нийт 72,041.3 сая төгрөгийн тусламжийн орлого, хөрөнгийн орлого 105.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 1,937.1 сая, өмнөх оны үлдэгдлээс 3,236.8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр 2021 онд аймгийн төсвөөс зарцуулах зарлагыг нийт 90,525.1 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн хуралдааны 3/10 дугаар тогтоолоор өмнөх оны төсвийн үлдэгдлийг 1143.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,853.3 сая төгрөгөөр, 2021.07.21-ний өдрийн хуралдааны 4/15 дугаар тогтоолоор аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж, анхны батлагдсан төсвийг 4,378.7 сая төгрөгөөр төсвийг нэмэгдүүлэн нийт 96,047.2 сая төгрөгөөр төсвийг баталсан байна.

Хүснэгт 1. Аймгийн 2021 оны төсвийн суурь зарлагын эх үүсвэр /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Баянхонгор аймаг, сумын нэр		
		Сангийн яамны хянасан дүн	2021 он	
			Анх батлагдсан	Аймгийн ИТХ-ын 2021.07.21-ний өдрийн хуралдааны 4/15 дугаар тогтоолоор тодотгол
А	Б	1	2	3
	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2020.11.13	2020.12.04	2021.07.21
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	84,397.0	90,525.1	96,047.2
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	84,397.0	85,726.2	89,006.0
	УРСГАЛ ОРЛОГО	11,127.7	13,204.9	13,721.6
	Татварын орлого	10,070.0	11,167.9	11,675.1
	Татварын бус орлого	1,057.7	2,037.0	2,046.5
	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	15.0	105.0	105.0
	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	73,254.4	72,416.3	75,179.4
	ӨМНӨХ ОНЫ ДАНСНЫ ҮЛДЭГДЭЛ	0.0	3,236.8	5,461.6
	СУМДЫН ТУСГАЙ САНГУУД	0.0	1,562.1	1,579.6
	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ЗАРЛАГА	84,397.0	90,525.1	96,047.2
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	77,145.8	81,671.6	86,309.9
	УРСГАЛ ЗАРДАЛ	77,145.8	81,671.6	86,309.9
	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	75,892.3	77,879.9	82,896.1
	ХҮҮ			
	ТАТААС	127.4	884.0	844.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,126.0	2,907.7	2,569.8
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,251.3	8,853.5	9,737.3
	НИЙТ ТЭНЦЭЛ			

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

Аймгийн Засаг дарга 2021 онд аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан аймгийн төсөвт нийт 3 удаагийн захирамжаар төсөвт зохицуулалт хийжээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1⁵, 42.2.2⁶ дахь заалт, аймгийн ИТХ-ын 2020.12.04-ний өдрийн “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 2/9 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021.04.26-ны өдрийн 1а/1993 “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2021.05.06-ний өдрийн А/289 дугаар захирамжаар аймгийн ЗДТГ-ын зардлаас засаг даргын нөөц хөрөнгийн зардалд 100.0 сая төгрөг, Халамжийн сан орон нутгийн төсвийн байгууллагад зардал хооронд 21,6 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн 12 сумын эрүүл мэндийн төвд бусад урсгал зардлаас эмийн зардалд 44.2 сая төгрөгийг, аймаг, сумын ЕБС-ын 29 байгууллагад цалингийн зардлаас хасаж урамшууллын зардалд 581.1 сая, Өлзийт, Жаргалан, Баянлиг сумдын болон Баянхонгор сумын 9 нийт 12 цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлаас 176.2 сая төгрөгийг хасаж цалин, урамшуулал болон бусад шаардлагатай зардалд нэмж төсөв хооронд зохицуулалт хийсэн;

- Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1⁷, 42.2.2⁸ дахь заалт, аймгийн ИТХ-ын 2021.07.21-ний өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөл оруулах тухай” 4/15 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021.04.26-ны өдрийн

⁵ “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно” 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:

⁶ “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”

⁷ “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно” 42.2.1.төсвийн ерөнхийлөн захирагч нь:

⁸ “Төсвийн захирагч төсөвтөө дараах байдлаар зохицуулалт хийж болно: төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд хамаарах төсвийн шууд захирагчдын төсөв хооронд”

1а/1993 “Чиглэл хүргүүлэх тухай “ албан бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2021.10.07-ний өдрийн А/629 дугаар захирамжаар орон нутгийн төсвийн байгууллагын 14 байгууллагад төсөвт 15.9 сая төгрөгийн зохицуулалт хийсэн

- Мөн дээрх тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжийн нэг дүгээр хавсралтаар орон нутгийн төсвийн 40 байгууллагад 260.8 сая, аймгийн Засаг даргын ерөнхий дансыг 165.7 сая төгрөгөөр бууруулан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлсэн, хоёр дугаар хавсралтаар боловсролын салбарын тусгай зориулалтын шилжүүлгийн 65 байгууллагад хоолны зардлын хэмнэлт 1,890.4 сая, үдийн цай хөтөлбөрийн хэмнэлт 380.1 сая, хичээл үйлдвэрлэлийн зардлын хэмнэлт 443.3 сая төгрөг, шуудан холбоо, хог хаягдлын зардлын хэмнэлт 20.4 сая төгрөгийг тус тус хасаж, цалингийн зардал 682.1 сая, НДШ зардал 27.1 сая, тээвэр шатахуун 37.6 сая, нормын хувцас зөөлөн эдлэл 91.6 сая, багаж техник хэрэгсэл 450.3 сая, урсгал засвар 103.9 сая, тавилга 72.4 сая, төлбөр хураамж 20.6 сая, нэг удаагийн тэтгэмж 35.4 сая, гамшгаас хамгаалах зардалд 164,4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн, гуравдугаар хавсралтаар эрүүл мэндийн салбарын тусгай зориулалтын шилжүүлгийн 20 байгууллага, 4 өрхийн эмнэлэгт 25.8 сая зардал хооронд зохицуулалт хийсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны орлогыг аймгийн ИТХ-аар 86,660.8 сая, сумын ИТХ-аар 8,975.2 сая, нийт 96,047.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт 2 .Төсвийн эх үүсвэр /аймаг, сумаар, сая төгрөгөөр/

НИЙТ ОРЛОГО	АЙМАГ	СУМ	ДҮН
Татварын орлого	8,252.1	3,422.9	11,675.1
Хүү, торгуулийн орлого	1,000.0	277.3	1,277.3
Хандив тусламжийн орлого	577.2	-	577.2
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	105.0	-	105.0
Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	17,503.5	-	17,503.5
Аймгийн төсөвт Улсын төсвөөс олгох ОНХС-ийн шилжүүлэг	8,091.9	-	8,091.9
Аймгийн төсөвт Улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	48,499.3	-	48,499.3
Аймгийн төсөвт Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох шилжүүлэг	640.5	-	640.5
Аймгийн орон нутгийн байгууллагын өөрийн орлого	118.0	74.1	192.1
Аймгийн төсвийн урьд оны үлдэгдэл	1,853.3	3,608.3	5,461.6
СХС-ийн зээлийн эргэн төлөлтийн орлого	-	1,579.6	1,579.6
ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	20.0	13.0	33.0
ОНХСангийн орлого	-	411.23	411.2
ДҮН	86,660.8	8,975.2	96,047.2

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль, Баянхонгор аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд

Аудитын илрүүлэлт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн орлогын төлөвлөгөө 96,047.2 сая төгрөг байхад Э-тайлангаар 90,112,9 сая төгрөгөөр буюу нь 5,934.3 сая төгрөгөөр зөрүүтэй татагдсан нь аймаг, сумын ИТХ-аар тодотгон баталсан татварын орлогын өөрчлөлт, бусад эс үүсвэрээс орох орлогыг программд татагдахгүй байгаагаас үйл ажиллагааны орлогыг 11.5 сая, хувь хүний орлогын албан татварын буцаан олгоолтыг 344.1 сая, ан амьтны нөөц ашигласны төлбөрийг 170.1 сая, бусад эх үүсвэрээс орох сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 5,408.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй татсанаас шалтгаалсан байна.

Иймд аймаг сумын ИТХ-аар тодотгон баталсан төсвийн орлого, татварын орлогын өөрчлөлтийг тухай бүр Сангийн яамны Э-тайланд үнэ зөв татуулан оруулж байх зөвлөмжийг аймгийн СТСХ-ийн дарга С.Байгалмаад хүргүүлж байна.

Татварын орлогыг өмнөх оны гүйцэтгэл, Сангийн яамнаас хянасан дүн, мэргэжлийн байгууллагуудаас ирүүлсэн судалгаанд үндэслэн төлөвлөсөн бөгөөд татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдүүлэн баталсан байна

Татварын орлогыг өмнөх онд 13,282.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 14,911.7 (112.0%) сая төгрөг орсон бөгөөд 2021 онд татварын орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 1260.8 сая, өмнөх оноос 914.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 10853.6 сая төгрөгөөр төлөвлөж, хувь хүний орлогын албан татварын буцаан олголтод Сангийн яамны баталсан дүнгээс 240.0 сая төгрөгөөр бууруулж, төрийн аудитын байгууллагын зөвлөмжийн дагуу өмнөх онуудын бодит гүйцэтгэлд тулгуурлан олгохоор 452.4 сая төгрөгийг олгохоор баталжээ.

Хүснэгт 3. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	2019 онд Сангийн яамны хянасан	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	2020 онд Сангийн яамны хянасан	2020 оны төлөвлөгөө	2020 оны гүйцэтгэл	2021 онд Сангийн яамны хянасан	2021 оны төлөвлөгөө	Өөрчлөлт	
									Өмнөх оны төлөвлөгөөнөөс	Сангийн яамны хянаснаас
Татварын орлогын дүн	8,572.3	10,118.4	11,928.5	9,600.0	13,272.8	14,911.7	11,232.7	13,826.6	553.8	2,593.9
1.Аймгийн нэгдсэн төсөв төсөв	5,281.9	5,399.0	5,782.4	5,550.0	6,604.1	7,183.0	6,720.0	7,088.6	484.4	368.6
а. ЦХТАО /суутган-1/	5,252.8	5,253.0	5,467.2	5,400.0	6,000.0	6,475.1	6,300.0	6,300.0	300.0	-
б. Хувь хүний орлогын буцаан олголт	(800.0)	(800.0)	(800.0)	(800.0)	(452.4)	(452.4)	(800.0)	(455.9)	(3.6)	344.1
в. АТӨЯХАТ	420.0	426.0	507.6	430.0	500.0	587.5	580.0	580.0	80.0	-
г.Газрын төлбөр	160.0	270.0	331.0	250.0	271.5	212.6	280.0	304.5	33.0	24.5
д. Үл хөдлөх хөрөнгийн татвар	249.1	250.0	276.6	270.0	285.0	360.2	360.0	360.0	75.0	-
2. Орон нутгийн төсөв	2,328.1	3,209.2	4,649.9	2,930.0	4,249.5	5,168.7	3,455.0	4,586.5	337.0	1,131.5
Хүн амын орлого	1,306.5	1,458.5	1,887.1	1,625.0	1,813.9	2,478.5	2,105.0	2,202.4	388.5	97.4
1. Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	308.0	381.0	549.4	430.0	462.6	1,009.1	600.0	639.8	177.2	39.8
2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар	96.1	100.0	142.5	50.0	52.4	139.6	250.0	250.0	197.6	-
3. Хөрөнгийн орлого /Хадгаламжийн хүү/	855.9	928.0	1,144.7	1,100.0	1,244.9	1,283.6	1,200.0	1,257.6	12.7	57.6
4. Бууны татвар	46.5	49.5	50.4	45.0	54.0	46.2	55.0	55.0	1.0	-
5. Бусад төлбөр хураамж	1,021.6	1,750.7	2,762.8	1,305.0	2,435.6	2,690.2	1,350.0	2,384.1	(51.5)	1,034.1
а.Улсын тэмдэгтийн хураамж	270.0	273.2	304.1	285.0	298.1	282.5	300.0	301.0	2.9	1.0
б. Газрын дуудлага худалдааны орлого	-	150.0	854.0	10.0	712.0	678.6	-	300.0	(412.0)	300.0
в. Орон нутгийн зам ашигласны төлбөр	-	194.6	220.1	-	220.0	253.1	-	240.0	20.0	240.0
г. Хог хаягдлын үйлчилгээний хураамж	300.0	506.2	487.0	400.0	656.3	673.4	670.0	716.0	59.7	46.0
д.ус рашаан ашигласны төлбөр	200.0	253.3	334.1	265.0	450.9	584.7	350.0	511.0	60.1	161.0
е..Түгээмэл тархацтай АМА Төлбөр	12.0	25.7	29.3	10.0	37.7	40.3	30.0	47.0	9.3	17.0
ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	239.6	339.5	524.9	335.0	55.6	176.5	-	234.1	178.5	234.1
ж.Нохойны татвар	-	8.2	9.3	-	5.0	1.2	-	-	(5.0)	-
з.Бусад татвар	-	-	-	-	-	-	-	-	-	-
и.Малын тоо толгойн албан татвар	-	-	-	-	-	-	-	35.0	35.0	35.0
Татварын бус орлого	962.3	1,434.2	1,425.1	1,070.0	2,319.2	2,290.9	1,042.7	2,046.5	(272.7)	1,003.9
а. Төсөвт байгууллагын өөрийн орлого	38.2	124.7	118.7	120.0	151.1	130.9	42.7	192.1	41.0	149.4
б. Хандив, тусламжийн орлого	-	350.0	135.0	-	1,200.0	563.6	-	577.2	(622.8)	577.2
Хүү, торгуулийн орлого	924.1	959.5	1,171.4	950.0	968.1	1,596.5	1,000.0	1,277.3	309.2	277.3
Хөрөнгийн орлого	-	76.0	71.2	50.0	100.0	269.1	15.0	105.0	5.0	90.0
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	-	76.0	71.2	50.0	100.0	269.1	15.0	105.0	5.0	90.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020, 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орлогын төлөвлөлтийг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад хүү торгуулийн орлогыг 33.7 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 164.1 сая төгрөг, бусад татварыг орлогын нэр төрөл тус бүрээр өмнөх оноос бууруулснаар татварын орлогыг 673.2 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 41.4 сая, хандив, тусламжийн орлогыг 13.6 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ.

Хүснэгт 4. Орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт

сая төгрөг

Д/Д	Орлогын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	орон нутгийн жилийн эцсийн тайлангаар			
			Төлөвлөгөө	Санхүүгийн тайланд гүйцэтгэл	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Зөрүү
1	А.Орон нутгийн нийт орлого	14,908.3	13,826.6	17,281.0	125.0	3,454.5
2	татварын дүн	12,348.3	11,675.1	15,179.4	130.0	3,504.4
3	1.Аймгийн төсөв	8,827.2	8,252.1	10,136.9	122.8	1,884.8
	1. ЦХТАО /суутган-1/	6,475.1	6,300.0	7,707.7	122.3	1,407.7
	Буцаан олголт	- 452.6	- 455.9	- 454.9	99.8	1.0
	2. АТӨЯХАТ	587.5	580.0	605.2	104.3	25.2
	3. Үл хөдлөх хөрөнгийн татвар	360.2	360.0	329.7	91.6	- 30.3
	4. Газрын төлбөр	117.5	174.1	300.5	172.6	126.4
	5. Ус рашаан ашигласны төлбөр	569.7	500.0	457.5	91.5	- 42.5
	6. УТХ	240.2	254.0	215.3	84.7	- 38.7
	7. Газрын дуудлага худалдаа	676.6	300.0	678.6	226.2	378.6
	8. Орон нутгийн зам ашигласны хураамж	253.1	240.0	297.4	123.9	57.4
	9. Хүү торгууль	1,285.6	1,000.0	1,474.9	147.5	474.9
	ТБӨО	98.2	118.0	114.8	97.3	- 3.2
	Хандив	563.6	577.2	84.0	14.6	- 493.2
	Орон нутгийн өмчийн хөрөнгө борлуулсны орлого	269.1	105.0	60.0	57.2	- 45.0
2	2. Орон нутгийн төсөв	3,521.1	3,422.9	5,042.5	147.3	1,619.6
1	1 Хүн амын орлого	2,292.7	1,897.4	2,052.0	108.2	154.7
	1..ИОТХ	1,009.1	639.8	604.2	94.4	- 35.5
	Хадгаламжийн хүүгийн орлого	1,283.6	1,257.6	1,447.8	115.1	190.2
2	2. Үл хөдлөх хөрөнгө борлуулсны	139.6	250.0	402.0	160.8	152.0
3	3. Бууны татвар	46.2	55.0	52.7	95.9	- 2.3
4	5. Бусад төлбөр хураамж	1,042.6	1,220.5	2,535.7	207.8	1,315.2
	а.УТХ	42.3	47.0	52.1	110.9	5.1
	4.Газрын төлбөр	95.1	130.4	183.1	140.4	52.7
	г. Хог хаягдлын хураамж	673.4	716.0	706.1	98.6	- 9.9
	д.ус рашаан ашигласны төлбөр	15.0	11.0	9.6	87.5	- 1.4
	е.Түгээмэл тархацтай АМАТөлбөр	40.3	47.0	39.2	83.3	- 7.8
	ё.Ан, амьтан агнуурын нөөц ашигласны	176.5	234.1	1,447.4	618.2	1,213.3
	Маын тоо толгойн татвар	-	35.0	98.2	280.7	63.2
6	Татварын бус орлого	310.9	277.3	313.9	113.2	36.6
	Хүү торгууль	310.9	277.3	313.9	113.2	36.6
7	ТБӨО	32.7	74.1	54.1	73.1	- 20.0

Хандив тусламжийн орлогыг аймгийн ОНХС-д 577.2 сая төгрөг оруулахаар аймгийн ИТХ-ын 2020.12.04-ний өдрийн 2/9 дугаар тогтоолоор баталсан.

Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг Сангийн яамнаас 15.0 сая төгрөгөөр хянаж ирүүлснийг 90.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний өдрийн 2/9 дугаар тогтоолоор 105.0 сая төгрөгөөр баталжээ.

Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 16,096.5 сая, ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2,862.0 сая, Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийг 45,980.2 сая, ЭМДС-аас олгох санхүүжилтийг 640.2 сая, урьд оны үлдэгдлээс 3,608.3 сая, татвар, хүү торгуулийн орлогоор 3,700.2 сая бусад 2,097.9 нийт 74,985.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Хүснэгт 5 .Сумдын төсвийн эх үүсвэрийн судалгаа /сая төгрөгөөр/

Санхүүжилтийн эх үүсвэр	Мөнгөн дүн	Хувь
Төсөвт байгууллагуудын өөрийн орлого	107.1	0.1%
ОНХС-ийн өөрийн орлогоор	411.2	0.5%
ЭМДС-ийн санхүүжилт	640.2	0.9%
СХС-ийн орлого	1,579.6	2.1%
ОНХС-ийн сангаас санхүүжих	2,862.0	3.8%
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,608.3	4.8%
татварын орлого	3,700.2	4.9%
Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	16,096.5	21.5%
Тусгай зориулалтын шилжүүлэг	45,980.2	61.3%
ДҮН	74,985.3	100.0%

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолууд

Сумдын дүнгээр нийт 74,985.3 сая төгрөг баталж төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 107.1 сая төгрөгөөр баталснаас Баянхонгор сумын ЗДТГ 40.1 сая, сумдын ЗДТГ 34.0 сая, Баацагаан, Бөмбөгөр, Шинэжинст, Баянцагаан сумын соёлын төвүүд өөрийн орлогоор 13.0 сая, Баянхонгор сумын Номгон ахлах сургууль, Номун далай цогцолбор сургууль тус бүр 10.0 сая, оруулахаар төлөвлөжээ.

Сумын Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн орлогын эргэн төлөлтөөр 2021 онд 20 сум 1,579.6 сая төгрөгийг 9 сум ОНХС-д 411.2 сая төгрөгийг тус тус оруулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 6 .Сумын СХС, ОНХС-ийн орлогын төлөвлөгөө /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	ОНХС-ийн орлогоор	СХС-ийн орлогоор	№	Сумын нэр	ОНХС-ийн орлогоор	СХС-ийн орлогоор
1	Галуут	120.0	75.0	11	Заг	-	29.0
2	Баян-Овоо	125.0	-	12	Баацагаан	53.3	63.5
3	Эрдэнэцогт	-	65.2	13	Бөмбөгөр	17.0	70.0
4	Бууцагаан	-	100.0	14	Өлзийт	12.8	35.0
5	Жинст	-	89.6	15	Хүрээмарал	52.1	60.1
6	Богд	-	65.0	16	Баянбулаг	-	70.0
7	Баянлиг	-	45.7	17	Шинэжинст	-	56.8
8	Баянговь	9.8	78.0	18	Баянцагаан	-	100.0
9	Гурванбулаг	-	72.5	19	Баян-Өндөр	-	131.5
10	Жаргалант	17.5	136.9	20	Баянхонгор	3.8	235.9
Нийт						411.2	1,579.6

Эх сурвалж: Сумдын ИТХ-ын тогтоолууд

1.2. Төлөвлөсөн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 125.0 хувиар биелүүлсэн ч аж ахуйн нэгжүүдээс “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээний 3,361.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Аймгийн дүнгээр 2021 онд орон нутгийн орлогоор 13,826.6 сая төгрөгийг оруулахаар баталж, гүйцэтгэлээр 17,281.0 (125%) сая төгрөгийг оруулж, төлөвлөгөөг 3,454.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	14,908.3	13,826.6	17,281.0	3,454.5	125.0
Татварын орлого	12,348.3	11,675.1	15,179.4	3,504.4	130.0
Орлогын албан татвар	8,315.1	7,741.4	9,304.8	1,563.4	120.2
Хөрөнгийн албан татвар	1,133.5	1,280.0	1,487.9	207.9	116.2
Бусад татвар, төлбөр хураамж	2,899.6	2,653.6	4,386.7	1,733.1	165.3
Татварын бус орлого	2,560.0	2,151.5	2,101.6	-49.9	97.7
Нийтлэг бус татварын орлого	1,727.4	1,469.3	1,957.6	488.3	133.2
Хөрөнгийн орлого	269.1	105.0	60.0	-45.0	57.2
Тусламжийн орлого	563.6	577.2	84.0	-493.2	14.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020, 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын илрүүлэлт:

- Тайланд онд аймгийн төсөвт орох татварын орлогыг 7,414.1 сая, сумын төсөвт орох татварын орлогыг 5,994.2 сая нийт 13,408.3 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 17,484.3 сая төгрөгийн татварын орлого тайлагнасан бол аймгийн Татварын хэлтсийн 2021 оны тайлангаар татварын орлогын гүйцэтгэлийг 17,550.0 сая төгрөгөөр тайлагнаж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас 65.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар дээрх зөрүү нь гарсан шалтгааны тодруулахад аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайланд бусад татвар дансанд орон нутгийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн дүнг бүртгэсэн, аймгийн Татварын алба орлогын гүйцэтгэлийн сар бүрийн мэдээнээс аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орлогыг мөнгөн сууриар бүртгэсэнээс зөрүү гарсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар сумдын орон нутгийн орлого, татварын байцаагчийн мэдээтэй зөрүүтэй 28.1 сая төгрөгийн зөрчилд 14 сумын Засаг даргад зөрчил арилгах зөвлөмжийг хүргүүлсэн.

Хүснэгт 8. Замд яваа татварын дүн сая төгрөгөөр/

№	Татварын нэр төрөл	Замд яваа мөнгөн хөрөнгө
1	ЦХТАО /суутган-1/	58.2
2	ҮХЭХ-ийн татвар	28.0
3	АТБӨЯХАТ	1.4
4	Газрын төлбөр	-0.8
5	Ус рашаан ашигласны төлбөр	-28.0
6	Орон нутгийн зам ашигласны хураамж	0.7
7	Хадгаламжийн хүүгийн орлого	11.8
8	Ойн нөөцийн төлбөр	0.5
9	Үйл ажиллагааны орлого 911, 912	5.3
10	Бууны татвар	0.3
11	Улсын тэмдэгийн хураамж	0.1
12	Түгээмэл тархацтай АМАТөлбөр	0.2
13	Хог хаягдлын хураамж	-0.5
14	Малын тоо толгойн татвар	0.2
15	Үл хөдлөх хөрөнгө борлуулсны татвар	0.3
		77.5

Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг 11,675.1 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 15,174.4 сая (130.0%) биелүүлсэн бөгөөд ан, амьтан агнуурын нөөц ашигласны орлого 618.2 хувь, малын тоо толгойн татвар, газрын дуудлага худалдааны орлого 226.2-280.7 хувь, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, улсын

тэмдэгтийн хураамж, орон нутгийн зам ашигласны хураамжийн орлогыг 104.5-160.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 9. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	14,908.3	13,826.6	17,281.0	3,454.5	125.0
Татварын орлого	12,348.3	11,675.1	15,179.4	3,504.4	130.0
Орлогын албан татвар	8,315.1	7,741.4	9,304.8	1,563.4	120.2
Хөрөнгийн албан татвар	1,133.5	1,280.0	1,487.9	207.9	116.2
Бусад татвар, төлбөр хураамж	2,899.6	2,653.6	4,386.7	1,733.1	165.3
Татварын бус орлого	2,560.0	2,151.5	2,101.6	-49.9	97.7
Нийтлэг бус татварын орлого	1,727.4	1,469.3	1,957.6	488.3	133.2
Хөрөнгийн орлого	269.1	105.0	60.0	-45.0	57.2
Тусламжийн орлого	563.6	577.2	84.0	-493.2	14.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлого давж биелэхэд дараах татварын орлого голлох нөлөөг үзүүлсэн байна. Үүнд:

- Баянхонгор аймагт Уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч Баян-овоо сумын нутагт байрлах "Наранмандал Энтерпрайзес" ХХК үйлдвэрийн ажилчдаа 2 дахин нэмэгдүүлж өргөтгөл хийсэн болон Баянхонгор аймагт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилчдыг ХХОАТ-өөр бүртгэх бодлого баримтлан ажилласан, Ковид цар тахалтай холбоотой эрүүл мэндийн салбарын ажиллагсдын цалин, илүү цагийн хөлс, урамшуулал олгосноор цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын орлогын албан татвар давж биелсэн.

- Төлөвлөгөөнд тусгагдаагүй бөгөөд нууцлалын зэрэгтэй барих зөвшөөрөл олгогддог шонхор шувууны нэг бүрийн үнэлгээ 27 сая төгрөг болж 3 дахин нэмэгдсэн улмаас ан амьтны нөөц ашигласны төлбөр орлогын төлөвлөгөө давж биелсэн.

- Малын тоо толгойн албан татварын хууль баталснаар орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бэлчээрийн ашиглалт, цөлжилт, худаг усны хангамж зэрэг асуудлаа бие даан шийдвэрлэх боломжийг олгосон. Өлзийт суманд малын тоо толгойн орлогын төлөвлөгөөгүй 61.2 сая төгрөгийн татвар төвлөрүүлснээр давж биелсэн

- Татварын шинэчлэлийн хүрээнд нэхэмжлэл нь иргэн дээр шууд үүсдэг болсон тул Улаанбаатар хотод үл хөдлөх хөрөнгө борлуулсан иргэний үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын албан татвар нь тухайн сумын дансанд шууд төвлөрдөг болсон болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалт урьд онуудаас өссөн учир төлөвлөгөө давж биелсэн байна.

- Хүү торгуулийн орлогыг 1,277.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс аймгийн Төрийн аудитын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газраас тогтоосон торгууль, төлбөрийн актын дүн өмнөх оноос нэмэгдсэнээс шалтгаалж, хүү торгуулийн орлогоор 1,788.8 (140%) сая төгрөгийг оруулжээ.

- 2020 оны жилийн эцэст аймгийн нийт хадгаламж эзэмшигчдийн хадгаламжийн дүн 165.5 тэрбум төгрөг байсан бол 2021 оны жилийн эцсийн байдлаар 209.4 тэрбум болж өссөнөөс шалтгаалан орлогын төлөвлөгөө давж биелсэн

21.Тайлант онд төлөвлөсөн татварын орлогыг биелүүлж ажилласан ч зарим татварын орлогын төлөвлөгөө биелээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлого ноос ноолуурын урамшуулал тооцоолсноос бага дүнгээр төвлөрсөнтэй холбоотой байна.

- Галт зэвсгийн албан татварын төлөгчдийн бүртгэлийн сантай тулган бүртгэлийн зөрүүг арилгах, татвар төлөгчийг татварт хамруулах ажлыг зохион ажилласан ба орлогын төлөвлөгөөг Баянхонгор, Гурванбулаг, Баян-Овоо, Бөмбөгөр, Хүрээмарал, Баянбулаг, Заг, Баян-Өндөр суманд тасарсан байна.

- Ус рашаан ашигласны төлбөр 1 аж ахуйн нэгжийн 35.8 сая төгрөгийн орлого төвлөрөөгүйгээс орлогын төлөвлөгөө тасарсан байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 2,680.2 сая, туслах үйл ажиллагааны орлогоор 166.0 сая төгрөг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоор 2,248.7 (83.9%) сая, туслах үйл ажиллагааны орлогоор 259.6 (156.4%) сая төгрөг оруулж, өөрийн орлогын төлөвлөгөө 88 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 10. Байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Байгууллага	Үндсэн үйл ажиллагаа				Туслах үйл ажиллагаа				Нийт орлого			
	Төл	Гүй	Зөрүү	Хувь	Төл	Гүй	Зөрүү	Хувь	Төл	Гүй	Зөрүү	Хувь
ЗДТГ	48.1	17.9	(30.2)	37.2%	126.0	122.3	(3.7)	97%	174.1	140.2	(33.9)	81%
ЕБС	20.0	10.0	(10.0)	50.2%	-	-	-		20.0	10.0	(10.0)	50%
Соёлын төв	13.0	5.1	(7.9)	39.2%	-	-	-		13.0	5.1	(7.9)	39%
СХС	1,562.1	1,736.4	174.3	111.2%	-	-	-		1,562.1	1,736.4	174.3	111%
ОНХС	447.8	386.1	(61.6)	86.2%	34.0	131.4	97.3	386%	481.8	517.5	35.7	107%
аймгийн ОНБ	12.0	8.7	(3.3)	72.1%	6.0	6.0	(0.0)	99%	18.0	14.6	(3.4)	81%
Аймгийн ОНХС	577.2	84.0	(493.2)	14.6%	-	-	-		577.2	84.0	(493.2)	15%
Өрхийн эмнэлэг	-	0.4	0.4		-	-	-		-	0.4	0.4	
ДҮН	2,680.2	2,248.7	(431.5)	83.9%	166.0	259.6	93.6	156.4%	2,846.2	2,508.3	(337.9)	88%

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хандив тусламжийн орлогыг аймгийн ОНХС-д 577.2 сая төгрөг оруулахаар аймгийн ИТХ-ын 2020.12.04-ний өдрийн 2/9 дугаар тогтоолоор баталж гүйцэтгэлээр 84.0 сая төгрөг орж хандивын орлогын төлөвлөгөө 493.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээний загварын 2.1.3 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалтыг үндэслэн “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай” гэрээг тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцан тохиролцож уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуйн нэгжтэй 9,150.0 сая төгрөгийн “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээ байгуулж 15 аж ахуйн нэгжээс 3,361.4 сая төгрөгийг дээрх гэрээний хүрээнд авч аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн

хуралдааны 3/12 дугаар “Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоолыг баталж зарцуулахдаа тухайн хандивлагч аж ахуйн нэгжээс гүйцэтгэгч компани руу шилжүүлэн төсвийн дансаар дамжуулаагүйтэй холбоотой байна.

Иймд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу төвлөрөх орлогыг орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлж Төсвийн тухай хуульд нийцүүлэн зарцуулж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан ХХОАТ-ын буцаан олголтод 2021 онд анх 800.0 сая төгрөг олгохоор батлагдаж, аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.07.21-ний өдрийн 4/15 дугаар тогтоолоор 344.1 сая төгрөгөөр бууруулж, 455.9 сая төгрөгөөр батлагджээ.

Аймгийн Татварын хэлтсийн даргын 2021.04.09-ний өдрийн А/11 дугаар тушаалаар 937 татвар төлөгчид 455.9 сая, 2021.06.24-ны А/32 дугаар тушаалаар 0.8 сая нийт 456.7 сая төгрөгийн албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэхээр баталж, гүйцэтгэлээр 454.9 сая төгрөг олгосон.

ТБОНӨХ-д бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор өмнөх онд 269.1 сая төгрөгийг оруулсан бол 2021 онд тус орлогыг Сангийн яамнаас 15.0 сая төгрөг баталсныг аймгийн ИТХ-аар 90.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 105.0 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 60.0 (45.0%) сая төгрөг оруулжээ.

Тайлант онд 13 автомашин худалдан борлуулахаас 13, 3 үл хөдлөх хөрөнгө борлуулахаас 1 үл хөдлөх хөрөнгийг борлуулж, дуудлага худалдааны орлогоор 55.1 сая, дуудлага худалдааны хураамжийн орлогоор 0.1 сая төгрөгийг оруулж, Баянхонгор аймгийн ОНӨГ-ийн хашааны түрээсийн орлого 4,0 сая нийт 60.0 сая төгрөгийн орлого оруулж орлогын төлөвлөгөө 45.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Сумдын 6 соёлын төв үйл ажиллагааны орлогоор 2020 онд 9.6 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 5.2 сая төгрөгийн орлого оруулсан бол тайлант онд 5 сум 13.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс 5.1 (39%) сая төгрөгийн орлого оруулж ажилласан нь дэлхий нийтэд гарсан цар тахлын улмаас соёлын арга хэмжээ явагдаагүйн нөлөөлсөн байна.

Сум хөгжүүлэх сангаас олгосон хөнгөлөлттэй зээл, зээлийн хүүгийн орлогоор тайлант онд 2,385.0 сая төгрөгийг оруулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 68.4 хувь буюу 1,631.1 сая төгрөг оруулсан ба Заг, Баянхонгор, Баян-Овоо, Баацагаан сумд сум хөгжүүлэх сангийн орлогыг 100 хувь бүрэн оруулсан бол Заг сум 91.3%, Баянбулаг сум 89.4%, Шинэжинст 86.1%, Баянцагаан 82.2%, Бууцагаан сум 81.5%-тай орлогын төлөвлөгөөг биелүүлсэн ба Жаргалант сум 24.9%, Баянговь сум 14.4%, Баянлиг 40.3%-тай орлогыг оруулж, хугацаа хэтэрсэн зээл өндөртэй байна.

Өмнөх оны сум хөгжүүлэх сангийн авлага 3,636.8 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан бол тайлант онд 2,671,8 сая төгрөг болж 965.0 сая төгрөгийн зээлийг авлагыг барагдуулж ажилласан байна.

Хүснэгт 11. Сумын сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	№	Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	1	2	3	4=3-2	5=3/2	А	1	2	3	4=3-2	5=3/2
1	Галуут	128.9	81.7	-47.2	63.4	11	Заг	90.0	82.2	-7.8	91.3
2	Баян-овоо	2.5	80.1	77.6	3204.0	12	Баацагаан	63.5	81.7	18.2	128.7
3	Эрдэнэцогт	95.2	69.0	-26.2	72.5	13	Бөмбөгөр	94.0	82.2	-11.8	87.5
4	Бууцагаан	100.0	81.5	-18.5	81.5	14	Өлзийт	154.7	68.4	-86.3	44.2
5	Жинст	148.4	78.1	-70.3	52.6	15	Хүрээмарал	71.7	52.9	-18.8	73.8
6	Богд	128.61	87.1	-41.5	67.7	16	Баянбулаг	82.9	74.1	-8.8	89.4
7	Баянлиг	165.4	66.6	-98.8	40.3	17	Шинэжинст	79.7	68.6	-11.1	86.1
8	Баянговь	213.0	30.7	-182.3	14.4	18	Баянцагаан	145	119.3	-25.7	82.2
9	Гурванбулаг	109.9	73.0	-36.9	66.4	19	Баян-өндөр	131.5	87.7	-43.8	66.7
10	Жаргалант	198.7	49.5	-149.2	24.9	20	Баянхонгор	181.4	216.5	35.1	119.4
Төлөвлөгөө 2,385.0 сая төгрөг, гүйцэтгэл 1,631.1 сая төгрөг Биелэлт 68.4%											

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймаг, сумын ИТХ-аар ЗДТГ-ын өөрийн орлогыг баталж, нийт 174.1 сая төгрөгийг оруулахаас 140.2 (81%) сая төгрөг оруулж, 8 сумын ЗДТГ тайлант оны орлогын төлөвлөгөөг биелүүлж, 14 сумын ЗДТГ орлогыг бүрэн оруулаагүй байна.

Хүснэгт 12. Сумын ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

№	Байгууллага	Үндсэн үйл ажиллагаа				Туслах үйл ажиллагаа				Нийт орлого			
		Төл	Гүй	Зөрүү	Хувь	Төл	Гүй	Зөрүү	Хувь	Төл	Гүй	Зөрүү	Хувь
1	Баянхонгор аймгийн ЗДТГ			-		100.0	100.2	0.2	100%	100.0	100.2	0.2	100%
2	Баянбулаг сумын ЗДТГ			-		1.0	1.0	-	100%	1.0	1.0	-	100%
3	Баянговь сумын ЗДТГ			-		1.0	1.8	0.8	184%	1.0	1.8	0.8	184%
4	Богд сумын ЗДТГ			-		1.0	0.4	(0.6)	40%	1.0	0.4	(0.6)	40%
5	Баянлиг сумын ЗДТГ			-		1.0	4.2	3.2	420%	1.0	4.2	3.2	420%
6	Баян-Овоо сумын ЗДТГ			-		1.0	0.3	(0.7)	34%	1.0	0.3	(0.7)	34%
7	Бөмбөгөр сумын ЗДТГ			-		1.0	0.4	(0.7)	35%	1.0	0.4	(0.7)	35%
8	Бууцагаан сумын ЗДБГ			-		1.0	0.3	(0.7)	32%	1.0	0.3	(0.7)	32%
9	Бх. Бх. Засаг даргын тамгын газар-9007377	30.7	-	(30.7)	0.0%	1.0	2.0	1.0	200%	31.7	2.0	(29.7)	6%
10	Бх. Бх. Шаргалжуут тосгон Захирагчийн ажлын алба-9007857	8.4	8.4	-	100.0%	-	-	-		8.4	8.4	-	100%
11	Баацагаан сумын ЗДТГ	9.0	9.5	0.5	105.5%	2.0	0.5	(1.5)	27%	11.0	10.0	(1.0)	91%
12	Баянцагаан сумын ЗДТГ			-		2.0	0.7	(1.3)	34%	2.0	0.7	(1.3)	34%
13	Баян-Өндөр сумын ЗДТГ			-		1.0	-	(1.0)	0%	1.0	-	(1.0)	0%
14	Галуут сумын ЗДТГ			-		1.5	0.9	(0.6)	61%	1.5	0.9	(0.6)	61%
15	Гурванбулаг сумын ЗДТГ			-		1.0	0.4	(0.6)	37%	1.0	0.4	(0.6)	37%
16	Жаргалант сумын ЗДТГ			-		1.0	1.4	0.4	136%	1.0	1.4	0.4	136%
17	Жинст сумын ЗДТГ			-		1.0	0.7	(0.3)	70%	1.0	0.7	(0.3)	70%
18	Заг сумын ЗДТГ			-		1.0	1.0	-	100%	1.0	1.0	-	100%
19	Хүрээмарал сумын ЗДТГ			-		1.0	0.4	(0.7)	35%	1.0	0.4	(0.7)	35%
20	Шинэжинст сумын ЗДТГ			-		1.0	0.0	(1.0)	1%	1.0	0.0	(1.0)	1%
21	Эрдэнэцогт сумын ЗДТГ			-		1.0	-	(1.0)	0%	1.0	-	(1.0)	0%
22	Өлзийт сумын ЗДТГ			-		4.5	5.8	1.3	128%	4.5	5.8	1.3	128%
ДҮН		48.1	17.9	(30.2)	37.2%	126.0	122.3	(3.7)	97.0%	174.1	140.2	81%	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

БҮЛЭГ 2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд нэмж төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан.

2.1. ТЕЗ-ийн батлагдсан төсвийг Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин гарсан, ЕБС-ийн урамшууллын зардлыг орон нутагт шилжүүлсэнтэй холбоотойгоор төсвийн жилийн дундуур тодотгол хийж төлөвлөгөөг 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн баталжээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны урсгал зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,253.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 81,671.6 сая, хөрөнгийн зардлыг 1,961.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,853.5 сая, нийт 90,525.1 сая төгрөгөөр анх баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.07.21-ний өдрийн 4/15 дугаар тогтоолоор Баянхонгор аймгийн 2021 оны нийт төсвийг 5,522.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 96,047.2 сая төгрөгөөр баталснаас урсгал зардлыг 4,638.2 сая, хөрөнгийн зардлыг 883.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт № 13 Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн батлагдсан төсөв

№	Зардлын төрөл	Өмнөх оны гүйцэтгэл	Анхны батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Төсөвт орсон өөрчлөлт
1	Урсгал зардал	80,417.8	81,671.6	86,309.9	4,638.2
2	хөрөнгийн зардал	6,891.7	8,853.5	9,737.3	883.8
	Нийт зардал	87,309.5	90,525.1	96,047.2	5,522.0

Төсвийн нийт зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 8,737.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна.

- ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг өмнөх оноос нэмэгдсэн.
- Баянцагаан, Жаргалант, Богд сумын Сум дундын эмнэлгүүд нь ЭМС-ын 2019 оны өдрийн А/540 дугаартай “Журам, шалгуур үзүүлэлт жагсаалт батлах тухай” тушаалаар сумын Эрүүл мэндийн төв болон аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн.
- Ковид цар тахал, малын гоц халдварт өвчин гарсантай холбоотойгоор аймаг сумын Засаг даргын нөөц хөрөнгө өссөн.
- УТХО-аар ашиглалтад орсон Галуут сумын Соёл, Заг сумын Соёл, Өлзийт сумын Соёлын төв, Баянбулаг сумын сургууль, Баян-Овоо сумын сургууль, цэцэрлэг, Номгон ахлах сургуулийн өргөтгөл, Номун далай ахлах сургууль ашиглалтад орсноор ашиглалтын зардал өссөн.
- Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөр үдийн хоол болсонтой холбоотойгоор аймаг, сумын ЕБС-д гал тогооны иж бүрэн тоног төхөөрөмж бэлтгэсэн.
- Шинэ суурьшлын бүсэд “Гэгээн сумади” сургууль цэцэрлэгийн цогцолбор 2021 оны 11 сараас эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд 2021.07.07-ний өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Баянхонгор аймагт улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлгийг 47,378.9 сая төгрөгийг 2255.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 14. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсөвт орсон өөрчлөлт

Байгууллага	Тоо	Анх батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
Ерөнхий боловсролын сургууль	30	23,756.3	25,784.9	2,028.6
Сургуулийн өмнөх боловсрол	36	12,420.3	11,526.8	(893.5)
Эрүүл мэндийн төв	20	8,668.2	8,668.2	(0.0)
Өрхийн эмт	4	836.0	836.0	-
Хувийн цэцэрлэг	7	496.7	449.2	(47.5)
Хувийн сургууль	2	165.7	185.8	20.0
ГБХЗХГ	1	463.0	461.8	(1.2)
ГХБХБГ	1	537.8	527.3	(10.5)
Насан туршийн боловсрол	1	35.0	59.4	24.4
Нийт	102	47,378.9	48,499.3	2,255.6

Эх сурвалж: МУ-ын Төсвийн тухай хууль, аймгийн ИТХ-ын тогтоол

Дээрх хуваарилсан тусгай зориулалтын шилжүүлгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээнд 9,504.2 сая, ерөнхий боловсролын үйлчилгээнд 26,030.1 сая, сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 11,976.0 сая, газрын харилцаа кадастрын үйлчилгээнд 527.3 сая, хүүхэд хөгжил хамгааллын үйлчилгээнд 461.8 сая төгрөгийг зарцуулахаар баталсан байна.



Баянхонгор аймгийн төсвийг 5,522.0 сая төгрөгийг нэмж тодотгохдоо дэлхий нийтийг хамарсан халдварт Ковид-19 цар тахал гарч, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжих, мөн сумдад мал гоц халдварт шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбоотой аймгийн ЗДТГ-т 1,636.0 сая, сумдын ЗДТГ-т 1,055.8 сая, ЕБС-уудийн зардлыг 2,793.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Хүснэгт 15. Байгууллагын төсөвт орсон өөрчлөлт /сая төгрөгөөр/

Зарлагын төрөл	Тоо	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Өөрчлөлт
Аймгийн 2021 оны төсвийн жилд зарцуулах зарлагын дүн	211	90,525.1	96,047.2	5,522.0
Аймгийн ИТХ	1	667.3	799.3	132.0
Аймгийн Засаг даргын тамгын газар	1	2,504.5	4,140.5	1,636.0
Сумдын ИТХ	20	1,727.8	1,887.4	159.7
Сумдын ЗДТГ	20	9,157.4	10,213.2	1,055.8
Сумдын Орон нутгийн хөгжлийн сан	20	3,887.0	4,065.5	178.5
Сумдын Сум хөгжүүлэх сан	20	2,872.9	2,897.8	24.9
Ерөнхий боловсролын сургууль	30	27,621.0	30,414.3	2,793.3
Цэцэрлэг	36	14,056.9	13,112.9	(943.9)
Сумдын эрүүл мэндийн төв	20	10,084.1	10,121.0	36.9
Сумдын соёлын төв	19	2,117.1	2,157.3	40.3
Асрамжийн газар	1	145.4	151.9	6.5
Засаг дарга /ангилагдаагүй зардал/	1	1,100.0	1,305.6	205.6
Аймгийн ахмадын байгууллага		118.1	118.1	-
Хотын нийтийн хүн тээвэр		48.0	8.0	(40.0)
Мал эмнэлгийн үйлчилгээний хөлс		709.3	709.3	-
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	731.7	740.7	9.0
Замын сан	1	895.0	947.7	52.7
Ойн анги	1	78.9	81.9	3.0
Халамжийн сан	1	150.2	150.2	-
Түүх угсаатны зүй, байгалийн музей	1	304.6	322.5	17.9

Нийтийн номын сан	1	175.2	176.8	1.6
Биеийн тамир спортын газар	1	432.1	436.6	4.6
Хүүхдийн Тэмүжин театр	1	461.2	460.3	(0.8)
Хөгжимт драмын театр	1	959.8	979.2	19.4
Хүүхэд, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	1	494.2	476.5	(17.7)
Санхүүгийн хяналт, аудитын алба	1	176.4	193.9	17.4
Орон нутгийн өмчийн газар	1	187.2	187.2	-
Хот тохижилт, үйлчилгээний газар	1	660.8	910.2	249.4
Гадаад харилцаа, аялал жуулчлалын алба	1	70.3	5.9	(64.4)
5 дугаар сургуулийн тогтмол зардал	1	862.0	115.8	(746.3)
Хувийн цэцэрлэгүүд		496.7	449.2	(47.5)
Хувийн сургууль		165.7	185.8	20.0
Өрхийн эмнэлэг	4	836.0	836.0	-
Аймгийн ОНХС	1	4,966.5	5,671.8	705.3
Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	1	569.0	557.4	(11.7)
Насан туршийн боловсрол	1	35.0	59.4	24.4

Эх сурвалж: *Аймаг, сумын ИТХ-ын тогтоолууд*

Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн ашиглалтын зардалд анх 862.0 сая төгрөгийг баталж, үйл ажиллагаа явуулж эхлээгүйгээс оны дундуур тус сургуульд хуваарилсан зардлыг бусад төсөвт байгууллагуудад хуваарилж байгаа зөрчил жил бүр давтагдан гарсаар байна.

2.2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд зарцуулж Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ТЕЗ-ийн гүйцэтгэлээр улсын төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 17,503.5 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 48,499.3 сая, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 8,091.9 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 484.1 сая төгрөгийн санхүүжилтийг авч, орон нутгийн орлогоос 11897.7 сая төгрөгийг зарцуулж, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор 2,508.3 сая төгрөгийн орлого оруулж, урьд оны үлдэгдлээс 1,853.0 сая төгрөг авч, тайлант оны эцэст орон нутгийн байгууллагууд 541.5 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 1,099.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, нийт 89,196.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Хүснэгт 16. Аудитлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлан / сая төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	96,047.2	89,196.8	6,850.3	92.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,309.9	81,653.4	4,656.5	94.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,896.1	78,413.8	4,482.3	94.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	46,791.3	46,119.4	671.9	98.6
210101	Үндсэн цалин	35,716.7	35,142.0	574.7	98.4
210102	Нэмэгдэл	7,466.4	7,517.4	(51.0)	100.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	337.7	319.9	17.8	94.7
210104	Урамшуулал	3,062.7	2,949.0	113.7	96.3
210105	Гэрээт ажлын хөлс	207.7	191.1	16.7	92.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,247.2	6,054.2	193.0	96.9
210201	Тэтгэврийн даатгал	4,489.8	4,361.4	128.3	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	437.9	425.9	12.0	97.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	352.0	336.8	15.2	95.7
210204	Ажилгүйдлийн даатгал	88.0	84.6	3.4	96.2

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
210205	Эрүүл мэндийн даатгал	879.5	845.4	34.1	96.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,641.4	9,069.0	572.4	94.1
210301	Гэрэл, цахилгаан	649.8	524.8	125.1	80.8
210302	Түлш, халаалт	8,441.9	8,047.3	394.6	95.3
210303	Цэвэр, бохир ус	474.0	421.3	52.7	88.9
210304	Байрны түрээс	75.6	75.6	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	3,376.3	3,207.5	168.8	95.0
210401	Бичиг хэрэг	300.0	300.3	(0.3)	100.1
210402	Тээвэр, шатахуун	1,264.8	1,241.1	23.7	98.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	239.5	212.4	27.1	88.7
210404	Ном, хэвлэл	83.6	76.3	7.3	91.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	990.2	885.4	104.8	89.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	498.2	492.0	6.3	98.7
2105	Нормативт зардал	2,511.4	2,159.3	352.0	86.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	724.9	721.4	3.5	99.5
210502	Хоол, хүнс	1,448.4	1,109.0	339.4	76.6
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	338.1	329.0	9.1	97.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,227.7	2,199.5	28.1	98.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	922.9	917.4	5.5	99.4
210602	Тавилга	342.9	339.3	3.6	99.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6.2	6.0	0.2	96.5
210604	Урсгал засвар	955.7	936.9	18.8	98.0
2107	Томилолт, зочны зардал	269.1	240.3	28.9	89.3
210702	Дотоод албан томилолт	238.6	210.7	28.0	88.3
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	30.5	29.6	0.9	97.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,619.1	1,500.0	119.1	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,452.1	1,342.6	109.5	92.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	44.5	43.3	1.2	97.4
210803	Даатгалын үйлчилгээ	20.0	19.3	0.7	96.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7.7	6.8	1.0	87.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	3.6	2.8	0.8	78.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	81.0	78.5	2.5	96.9
210807	Газрын төлбөр	9.8	6.5	3.4	65.8
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.1	0.1	-	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.1	0.1	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,212.7	7,864.6	2,348.0	77.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,185.0	6,855.3	2,329.7	74.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,027.7	1,009.3	18.4	98.2
212	ТАТААС	844.0	867.0	(23.0)	102.7
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	844.0	867.0	(23.0)	102.7
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	844.0	867.0	(23.0)	102.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,569.8	2,372.6	197.1	92.3
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	947.7	904.4	43.3	95.4
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	947.7	904.4	43.3	95.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,622.1	1,468.3	153.8	90.5
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	145.2	138.2	7.0	95.2
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24.0	24.0	0.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	737.3	594.7	142.6	80.7
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	489.3	488.7	0.6	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	226.2	222.6	3.6	98.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,737.3	7,543.4	2,193.9	77.5
220001	Барилга байгууламж	9,737.3	7,543.4	2,193.9	77.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	96,047.2	91,258.3	4,788.9	95.0

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	48,499.3	47,399.8	1,099.5	97.7
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	48,499.3	47,399.8	1,099.5	97.7
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,090.5	40,866.1	1,224.4	97.1
320001	Орон нутгийн төсвөөс	33,998.6	32,774.2	1,224.4	96.4
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	8,091.9	8,091.9	0.0	100.0
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	640.5	484.1	156.3	75.6
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	640.5	484.1	156.3	75.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,816.9	2,508.3	2,308.6	52.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,680.2	2,248.7	431.5	83.9
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	166.0	259.6	(93.6)	156.4
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,970.7	-	1,970.7	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,157.5	(2,157.5)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	4,218.9	(4,218.9)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	33,488	73,593	(40,105)	219.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	169	169	-	100.0
610001	Төсвийн байгууллага	160	160	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	9	9	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,951	3,931	20	99.5
620001	Удирдах ажилтан	306	296	10	96.7
620002	Гүйцэтгэх ажилтан	2,510	2,502	8	99.7
620003	Үйлчлэх ажилтан	1,073	1,073	-	100.0
620004	Гэрээт ажилтан	62	60	2	96.8
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	25,417	24,850	567	97.8
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	19,287	19,352	(65)	100.3
630001	Төрийн өмчит ЕБС	18,364	18,429	(65)	100.4
630002	Хувийн ЕБС	923	923	-	100.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	6,130	5,498	632	89.7
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	6,130	5,498	632	89.7
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	40,712	(40,712)	
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	-	10,873	(10,873)	
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	-	29,839	(29,839)	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Засгийн газрын 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар:

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол гарсантай холбоотой БШУ-ны сайдын 2021.04.26-ны өдрийн 1а/1993 дугаар тушаалаар боловсролын салбарын 2021 оны төсвийн жилд батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсөв захирагч нарт үүрэг болгож чиглэл хүргүүлсэн.

Засгийн газрын 43 дугаар тогтоол болон БШУ-ны сайдын 1а/1993 тоот тушаалыг үндэслэн аймгийн Засаг даргын 2021.05.06-ны өдрийн А/289, 2021.10.05-ны өдрийн А/629 дүгээр захирамжуудаар тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс ЕБС, цэцэрлэгийн цалин, хоолны зардлыг бууруулж урамшууллыг нэмэгдүүлсэн, ЭМТ-ийн хэмнэгдэх боломжит зардлуудыг бууруулж эмийн зардлыг нэмэгдүүлсэн, орон нутагт төсөвт байгууллагуудын хэмнэгдэх зардлуудыг цалин, Засаг даргын нөөц хөрөнгөд шилжүүлж зохицуулалтыг хийсэн байна.

Хүснэгт №17 Аймгийн Засаг даргын 2021 оны А/289, А/629 дугаар захирамжуудын нэгтгэл

Зардлын төрөл	Сургууль	Цэцэрлэг	Эрүүл мэндийн төв	Орон нутгийн төсөвт	Нийт
Үндсэн цалин	(538.6)	122.6	(6.6)	22.2	(400.3)
Нэмэгдэл	-	-	(6.6)	-	(6.6)
Хоол унааны хөнгөлөлт	-	-	(6.5)	(1.8)	(8.3)
Урамшуулал	581.1	31.5	(2.6)	-	609.9
НДШ	4.4	20.2	(3.0)	1.5	23.0
Бичиг хэрэг	-	-	-	(8.5)	(8.5)
Тээвэр шатахуун	1.0	-	(23.0)	(1.5)	(23.5)
Шуудан холбоо	0.8	0.4	0.3	(7.0)	(5.5)
Байр ашиглалттай холбоотой	-	-	-	(39.3)	(39.3)
Хог хаягдал устгах	-	-	2.5	-	2.5
Нормын хувцас зөөлөн эдлэл	(0.8)	(0.4)	(1.5)	0.5	(2.2)
Эм бэлдмэл	1.0	-	44.2	-	45.2
Хоол	(38.5)	(176.3)	1.5	(4.0)	(217.3)
Дотоод албан томилолт	-	-	(2.8)	(5.5)	(8.3)
Зочид төлөөлөгчид хүлээн авах	-	-	-	(16.5)	(16.5)
Урсгал засвар	-	-	-	18.0	18.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	-	(9.7)	(2.3)	(12.0)
Бараа үйлчилгээний бусад зардал хичээл үйлдвэрлэл	-	-	13.7	(53.6)	(39.9)
Үдийн цай	(15.4)	-	-	-	(15.4)
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-	-	2.5	2.5
тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж	-	-	-	10.5	10.5
Нийгмийн халамж	-	-	-	(5.0)	(5.0)
Гамшгаас хамгаалах сан	5.0	2.0	-	-	7.0
Засаг даргын нөөц хөрөнгө	-	-	-	90.0	90.0

БШУ-ын сайдын 2021.11.11-ний өдрийн 1а/5843 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг хөтөлбөр хооронд зохицуулалт хийхийг зөвшөөрөл олгосны дагуу аймгийн Засаг даргын Төсвийн аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх тухай 2021.12.06-ний өдрийн А/742 дугаар захирамжаар дараах зохицуулалтыг хийсэн.

Дээрх захирамжаар цэцэрлэгийн нийт төсвөөс 214.7 сая төгрөгийг хасаж ЕБС-ийн төсвийг нэмэгдүүлсэн ба үүн хоол хүнс, үдийн цай, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зэрэг 2,891.1 сая төгрөгийн зардлыг хасаж цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эм, тавилга, урсгал засвар, Засаг даргын нөөц хөрөнгө, гамшгаас хамгаалах зэрэг зардлуудыг нэмэгдүүлсэн байна.

Мөн орон нутгийн төсөвт аймгийн Засаг даргын ангилагдаагүй зардал, байр ашиглалттай холбоотой зардал цалин хөлс зэрэг зардлуудыг 329.2 сая төгрөгөөр хасаж багаж техник хэрэгсэл худалдан авах, урсгал засвар, Засаг даргын нөөц хөрөнгө зэрэг зардлуудыг нэмэгдүүлж зохицуулалт хийсэн байна.

Хүснэгт №18 Аймгийн Засаг даргын 2021 оны А/742 дугаар захирамжийн нэгтгэл

Зардлын төрөл	Тусгай зориулалтын шилжүүлэг			Орон нутгийн төсөвт	Нийт
	ЕБС	Цэцэрлэг	ЭМТ		
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	675.5	6.5	(86.1)	(35.1)	560.8
НДШ	35.2	(6.4)	(11.2)	(5.9)	11.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	(117.5)	(117.5)
Хангамж, бараа материалын зардал	156.6	208.6	20.7	5.3	391.2

Эм бэлдмэл	73.0	74.3	64.0	-	211.3
Хоол, хүнс	(804.2)	(1,086.1)	1.2	(1.3)	(1,890.5)
Нормын хувцас зөөлөн эдлэл	91.6	91.1	0.7	(2.7)	180.7
Багаж, техник хэрэгсэл	450.3	244.1	26.0	22.8	743.3
Тавилга	72.4	43.5	13.4	3.0	132.3
Урсгал засвар	103.9	62.4	25.6	126.5	318.4
Дотоод томилолт	(1.2)	1.0	(9.6)	8.9	(1.0)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	20.9	14.3	(16.0)	3.0	22.2
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	(28.6)	5.9	(22.7)
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	(479.0)	35.7	-	3.9	(439.3)
Засаг даргын нөөц хөрөнгө	-	-	-	142.0	142.0
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	35.4	30.7	-	6.2	72.2
Бусад ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	-	-	-	1.7	1.7
Үдийн цай	(380.1)	-	-	-	(380.1)
Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаа	164.4	65.6	-	(1.0)	229.0
Аймгийн Засаг даргын ангилалдаагүй зардал				(165.7)	(165.7)
НИЙТ ДҮН	214.7	(214.7)	0.0	-	0.0

Аудитын илрүүлэлт:

- Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нийт батлагдсан төсөв 96,047.2 сая төгрөг ба гүйцэтгэлээр 89,196.8 сая төгрөг зарцуулж төсөвт 7.1 хувийн хэмнэлт гаргасан байгаа нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалттай нийцэхгүй байна.

- Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн А/742 тоот захирамжаар хийсэн зохицуулалтаар урсгал үйл ажиллагааны зардлыг бууруулж 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд нэмж төсөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.7⁹ дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4¹⁰ дэх заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал: Боловсрол соёл, урлагийн газраас аймгийн Засаг даргад 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 375 тоот албан бичгээр тайлант оны хэмнэгдэж буй үдийн цай, хүүхдийн хоол, тогтмол зардалд зохицуулалт хийлгэх хүсэлт хүргүүлэн шийдвэрлүүлж 220,000.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу хэмнэлт үүсэх боломжтой байсан зардлуудыг зарцуулсан.

Дээрх хөрөнгө нь ЕБС-ын хичээл сургалтын үйл ажиллагаанд хэрэгтэй хөрөнгө оруулалт боловч, сургууль бүрийн төсөвт санхүүжилтийн зохицуулалт хийхдээ тендерийн босго үнээс доогуур 9.5 сая төгрөгөөр хуваарилуулан он дараалан нэг аж ахуй нэгж болох “Санко Маркетинг Монголиа” ХХК-аас шууд худалдан авалт хийсэн байна.

Баянхонгор сумд үйл ажиллагаа явуулж байгаа СӨБ-ын 7 цэцэрлэгт 2021 онд хоолны зардал болон бусад зардлын хэмнэлтийг бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авах зардалд тодотгуулан 2021 оны 10-12 дугаар сард “Окфил эко” ХХК-аас нэг бүр нь 106.0 мянган төгрөгийн үнэ бүхий 373 ширхэг агаар шүүгчийг 39.5 сая төгрөгөөр 2021 онд худалдан авсан, Баянхонгор сумын 12 дугаар цэцэрлэг 2020 онд 4.1 сая төгрөгийн 42 ширхэг цонхны агаар шүүгч авсан ба 2021 онд тус шүүгчийн шүүрийг солиход 0.4 сая төгрөг зарцуулсан байна. Тухайлбал 6 дугаар цэцэрлэг 80 ширхэг, 3 дугаар цэцэрлэг 68 ширхэг, 16 дугаар цэцэрлэг 98 ширхэг агаар шүүгчийг цэцэрлэгийн барилгын цонхонд суурилуулсан байгаагаас үзэхэд жил бүр урсгал зардалд нь дээрх цэцэрлэгүүдэд нийтдээ 3.5 сая төгрөгийн зардал нэмэгдэхээр байна.

⁹ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

¹⁰ 1.4. энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албаны конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

Цаашид “Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлж нэн шаардлагатай тоног төхөөрөмж, аж ахуйн материалын жагсаалтыг гарган хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэн төсвийн төсөлдөө тусган хүргүүлж, батлагдаагүй зардлыг төсөвт зохицуулалт хийлгэн санхүүжүүлэхгүй байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ болон ТБОНӨААН-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг 76 байгууллага хэрэгжүүлээгүйгээс нийт 700.4 сая төгрөгийн зөрчил илэрч 2 байгууллагад 3.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 7 байгууллагад 56.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 67 байгууллагад 640.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.

Тайлант онд улсын төсвөөс олгосон 48,499.3 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийг яамдаар нь авч үзвэл нийт зардлын 78.4 хувийг БСШУС, 19.6 хувийг ЭМС, 1.0 хувийг ХАХНХС, 1.1 хувийг БХБС-ын багцын байгууллагуудын зардал эзэлж байгаа ба санхүүжилтийг бүрэн авч, батлагдсан зардлын 97.7 хувийг буюу 47,399.8 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 1,099.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Тусгай зориулалтын шилжүүлгийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, яамдаар /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Нийт дүн	Үүнээс:			
		БСШУС-ын сайд	ХАХНХ-ын сайд	ЭМС-ын сайд	БХБ-ын сайд
Батлагдсан төсөв	48,499.3	38,006.1	461.8	9,504.2	527.3
Олгосон урсгал санхүүжилт	48,499.3	38,006.1	461.8	9,504.2	527.3
Зардлын гүйцэтгэл	47,399.8	37,028.0	456.0	9,393.2	522.7
Зардлын гүйцэтгэл /хувиар/	97.7	97.4	98.7	98.8	99.1
Улсын төсөвт төвлөрүүлсэн дүн	1,099.5	978.1	5.8	111.0	4.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ТЕЗ-ийн нийт зардлыг өмнөх онуудтай харьцуулахад зардал инфляцын түвшин нэмэгдсэнээс шалтгаалж жил бүр зардлын дүн өссөн байна.

Хүснэгт 19. Зардлын харьцуулсан судалгаа /сая төгрөгөөр/

Он	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2019	Урсгал	72,046.1	69,953.1	2,093.0
	Хөрөнгийн	7,793.1	6,584.3	1,208.8
2020	Урсгал	85,508.9	80,417.8	5,091.1
	Хөрөнгийн	8,729.2	6,891.7	1,837.5
2021	Урсгал	86,309.9	81,653.4	4,656.5
	Хөрөнгийн	9,737.3	7,543.4	2,193.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2019, 2020, 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант онд аймгийн ТЕЗ-ийн нийт зардлын гүйцэтгэл өмнөх оноос 1,887.3 сая төгрөгөөр нэмэгдэж, 89,196.8 сая төгрөгийг зарцуулснаас 91.5 хувь буюу 81,653.4 сая төгрөгийг урсгал зардалд, 8.5 хувь буюу 7,543.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулжээ.

Хүснэгт 20. Зардлын гүйцэтгэл /сая төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	2020 оны гүйцэтгэл	2021 оны гүйцэтгэл	Эзлэх хувь	Өмнөх оноос өөрчлөлт
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	87,309.5	89,196.8	100.0	1,887.3
УРСГАЛ ЗАРДАЛ	80,417.8	81,653.4	91.5	1,235.6
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	77,492.4	78,413.8	96.0	921.4
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	43,806.6	46,119.4	58.8	2,312.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,637.3	6,054.2	7.7	416.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,142.4	9,069.0	11.6	926.6
Хангамж, бараа материалын зардал	2,173.0	3,207.5	4.1	1,034.5
Нормативт зардал	4,043.5	2,159.3	2.8	(1,884.1)
Эд хогшил, урсгал засварын зардал	1,920.4	2,199.5	2.8	279.1
Томилолт, зочны зардал	313.8	240.3	0.3	(73.5)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,727.0	1,500.0	1.9	(2,227.0)
Бараа үйлчилгээний бусад зардал	7,728.4	7,864.6	10.0	136.2
ТАТААС	835.6	867.0	1.1	31.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,089.8	2,372.6	2.9	282.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,891.7	7,543.4	8.5	651.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2020, 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрснийг цаашид анхаарч, дүн шинжилгээ хийж ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Цалингийн зардал:

Цалингийн зардлыг анх 44,757.5 сая төгрөгөөр баталсныг оны дундуур төсөвт хийсэн төсөвт зохицуулалтаар 2,033.8 сая төгрөгөөр нэмж, 46,791.3 сая төгрөгөөр батлан, гүйцэтгэлээр 46,119.4 сая төгрөгийг олгож, цалингийн зардлыг 671.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хүснэгт 21. Цалингийн зардал /сая төгрөгөөр/

№	Салбарын нэр	Анх батлагдсан төсөв	Зохицуулалт хийсэн дүн	Оны эцсийн төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Орон нутаг	11,513.0	164.6	11,677.5	11,545.3	132.2
2	Боловсрол	26,344.9	1,977.7	28,322.6	27,945.0	377.6
3	Эрүүл мэнд	6,899.7	(108.4)	6,791.2	6,629.1	162.1
	Дүн	44,757.5	2,033.8	46,791.3	46,119.4	671.9

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн төсвийн мэргэжилтнээс ирүүлсэн судалгаа

Төрийн албан хаагчийн буруу шийдвэр гаргасны улмаас төрд 20.6 сая төгрөгийн хохирол учруулсан төлбөрийг цалингийн зардлаас олгож шүүхийн шийдвэр гарсан ч төрд учирсан хохирлыг барагдуулаагүй байна.

Тухайлбал:

- Жаргалант сумын ЕБС-ийн сургалтын менежер захирлын үүргийг хавсран гүйцэтгэж байсан Б.Саранцэцэгийг аймгийн Засаг даргын 2020.07.01-ны өдрийн Б/09 дугаар захирамжаар Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд өөрчлөлт орсны дагуу ажлаас халагдаж эргүүлэн сумын Засаг дарга ажилд томилохоор байхад томилоогүй тул шүүхэд хандсан байна. Шүүхээр сургуулийн захирлын ажилд эгүүлэн томилж ажилгүй цалин 3.5 сая төгрөгийг гаргуулах, 0.3 сая төгрөгийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд нөхөн бичилт хийлгүүлэх шийдвэр гарсан.

- Баянхонгор аймгийн Баянговь сумын ЗДТГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 11 дүгээр тушаалыг хүчингүй болгож сумын Санхүүгийн албаны даргын ажилд эгүүлэн тогтоолгож 2017.04.03-2018.05.29 өдрийг хүртэл ажилгүй байсан хугацааны цалин гаргуулж эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх шийдвэр гарсны дагуу ажил олгогчоос төлөх НДШ ийн 0.7 сая төгрөгийг тайланд оны нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн.

- Баянхонгор аймаг дахь Сум дундын шүүхийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2021 оны 03 дугаар сарын 09-ний 131/ШШ2021/00171 тоот захирамжаар нягтлан

бодогчоор ажиллаж байсан Т.Нарангаравын Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 54 дугаар бүхий тушаалаар ажлаас халагдаад ажилгүй байсан хугацааны цалингийн нөхөн олговорт 3.3 сая төгрөгийг цалингийн зардлаас олгосон.

- Баянхонгор аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн дугаар Б/509 захирамжийг хүчингүй болгож Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын ажилд эгүүлэн тогтоолгож ажилгүй байх хугацааны цалин болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхээр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.04.16-ны өдрийн 275 тоот магадлал, Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021.01.18-ний өдрийн 131/ШЗ202/00192 захирамжийн дагуу иргэн В.Нарантуяад 12.6 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын төсвөөс олгосон байна.

Дээрх 4 албан тушаалтантай холбоотой төрд учирсан 20.6 сая төгрөгийн хохирлыг барагдуулах албан шаардлагыг ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанд хүргүүлсэн болно.

Төсвийн шууд захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар цалин, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан, цалингийн тооцооллыг зөрүүтэй гүйцэтгэсэн, цалингийн санг Нийгмийн даатгалын хэлтэс зөрүүтэй мэдээлдэг зэргээр 49 байгууллагад 74,435.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал:

Төсөвт байгууллагуудын байр ашиглалттай холбоотой зардлыг анх 9,907.3 сая төгрөгөөр баталж, жилийн явцад 266.0 сая төгрөгөөр бууруулж зохицуулалт хийж 9,641.4 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 9,069.0 сая төгрөг зарцуулж, Монгол улсын Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.8. “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах,” хэрэгжүүлэн аймгийн Засаг даргын 2021.04.21-ны өдрийн “Халаалтын үйл ажиллагааг зогсоох тухай” А/270 дугаарт захирамжаар сумдын ЭМТ, аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилгын халаалтаас бусад говийн сумд 2021.04.25-ны өдөр, аймгийн төв болон хангайн сумд 2021.05.01 өдөр халаалтын үйл ажиллагааг зогсоох захирамж гаргаснаас 572.4 сая төгрөгөөр хэмнэсэн нь байна.

Хүснэгт 22.Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал /сая төгрөг/

д/д	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү
1	Гэрэл цахилгаан	649.8	524.8	125.1
2	Түлш халаалт	8,441.9	8,047.3	394.6
3	Цэвэр бохир ус	474.0	421.3	52.7
4	Байрны түрээс	75.6	75.6	-
	Нийт дүн	9,641.4	9,069.0	572.4

Эх үүсвэр:Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үдийн цайны зардал:

Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчдад олгох үдийн цайны зардлыг өмнөх оноос 286.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 737.3 сая төгрөгөөр баталсан нь Засгийн газрын 2021.08.11-ний өдрийн 237 дугаар тогтоолоор үдийн хоол болгож нормативыг 1500 төгрөгөөр тогтоон 2021.09.01-ний өдрөөс мөрдүүлсэнтэй холбоотой байна.



Үдийн хоолны зардлыг анх батлагдсан 1,272.7 сая төгрөгийн төсвийг Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотой 535.4 сая төгрөгөөр хасаж тодотгон гүйцэтгэлээр 594.7 сая төгрөг зарцуулан 142.6 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Эрдэнэцогт сумын ЕБС нь үдийн цайны зардлаас 1.4 сая, хоол хүнсний зардлаас 1.6 сая төгрөгийн хүнсний материал авч нөөц бүрдүүлсэн.
- Жинст сумын ЕБС нь "Эх арцат" ХХК-д 2021.03.24-ны өдөр 2.7 сая, "Их богдын ундарга" ХХК -д 4.1 сая нийт 6.8 сая төгрөг шилжүүлж хүнсний материалыг худалдан авч 3 сарын үдийн цайнд 1.8 сая, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 3.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Харин ковид-19 цар тахал гарсантай холбоотой сургууль хичээллээгүй бөгөөд мах болон бусад хүнсний материал муудаж Жинст сумын сургуулийн захирлын 2021.10.01-ний өдрийн 46 дугаар тушаалаар 2.6 сая төгрөгийн хүнсний материалыг акталсан.
- Баянхонгор сумын 1 дүгээр цэцэрлэгийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар үдийн цайны зардлын нормативыг хэтрүүлэн илүү зарцуулсан 0.6 сая төгрөгийг холбогдох буруутай албан тушаалтнуудаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон ч хүнсний зардлаас төлсөн.

Хоолны зардал:

Аймгийн дүнгээр хоолны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 1,741.5 сая төгрөгөөр бууруулж, 1,448.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,109.0 сая төгрөг зарцуулж, 339.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 23. Хоолны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургууль	584.8	466.6	118.2
2	Цэцэрлэг	701.9	484.2	217.8
3	Эрүүл мэндийн төв	126.5	123.2	3.3
4	Бусад төсөвт байгууллагууд	35.2	35.0	0.1
Дүн		1,448.4	1,109.0	339.4

Эх сурвалж. Баянхонгор аймгийн ТЭЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Томилолт, зочны зардал:

Томилолт, зочны зардлын 2020 оны гүйцэтгэл 313.8 сая төгрөг байсан ба тайланд онд өмнөх оноос 44.7 сая төгрөгөөр бууруулж, 269.1 сая төгрөгөөр баталснаас 240.3 сая төгрөгийг зарцуулж, 28.9 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 24. Томилолт зочны зардлын харьцуулсан судалгаа / сая төгрөгөөр/

Зардлын төрөл	2020 он			2021 он		
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт
Гадаад албан томилолт	19.3	18.3	1.0			-
Дотоод албан томилолт	322.7	249.5	73.2	238.6	210.7	28.0
Зочин төлөөлөгч хүлээн авах зардал	46.8	46.0	0.8	30.5	29.6	0.9
Дүн	388.7	313.8	74.9	269.1	240.3	28.9

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Номундалай цогцолбор сургууль нь томилолтын зардлаас 2021.06.23-ны өдөр 0.1 сая төгрөгийг зориулалт бусаар олгосон.
- Баянхонгор сумын 15 дугаар цэцэрлэгийн дарга, 5 багшийн хамт Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн 157 дугаар Цэцэрлэгээс туршлага судлах ажлаар 2021.10.01-02-ны өдрүүдэд ажиллахаар 0.6 сая төгрөгийн албан томилолт авч явсан ба томилолтоор ажилласан хугацаа, томилолтын тайлан бичсэн хугацаа зөрүүтэй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй.
- Бууцагаан сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэн нэр данс зөрүүтэй 0.4 сая төгрөгийн буцаж орсон гүйлгээг бараа үйлчилгээний зардлаар бүртгэлгүй, томилолтын зардлаар хааснаас төсвийн гүйцэтгэлийн тайланд дээрх 0.4 сая төгрөгөөр зардал хооронд зөрүү үүсэж тайлан буруу илэрхийлэгдсэн байна.
- Галуут сумын ЗДТГ-ын 2021 оны төсөвт зочид төлөөлөгч хүлээн авах зардалд нийт 1.5 сая төгрөг батлагдаж, 0.9 сая төгрөгийг биеийн тамирын арга хэмжээ болон, Майдар эргэх ёслолын арга хэмжээнд, 0.2 сая төгрөгийн махны үнэ төлсөн байна.

Тээвэр, шатахууны зардал:

Тайлант онд тээвэр, шатахууны зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 132.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,264.8 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,241.1 сая төгрөг зарцуулж, зардлыг 23.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тээвэр шатахууны зардлыг төсвийг анх 1,187.2 сая төгрөгөөр төлөвлөснийг 77.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,264.8 сая төгрөгөөр баталсан ба үүнд малын гол халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой сумдын ИТХ, ЗДТГ-ын төсвийг 74.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

ТЭЭВЭР ШАТАХУУН



Хүснэгт 25. Тээвэр, шатахууны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Анх батлагдсан	Тодотгосон	Өөрчлөлт	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сургууль	40.1	61.5	21.4	62.0	(0.5)
2	Цэцэрлэг	52.1	69.1	17.1	66.1	3.0
3	Эрүүл мэндийн төв	411.1	383.4	(27.8)	376.8	6.5
4	Соёлын төв	21.3	22.0	0.8	21.9	0.2
5	Аймгийн ИТХ	20.0	25.0	5.0	25.0	-
6	Сумдын ИТХ	68.7	90.2	21.5	86.6	3.6
7	Аймгийн ЗДТГ	90.0	77.4	(12.6)	77.4	-
8	Сумдын ЗДТГ	416.5	469.4	52.9	461.6	7.8
9	Бусад төсөвт байгууллагууд	67.6	66.8	(0.8)	63.8	3.0
	Дүн	1,187.2	1,264.8	77.6	1,241.1	23.7

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Баянбулаг, Бөмбөгөр сумын ЕБС, хүүхдийн Тэмүүжин театр нь нийт 5.1 сая төгрөгийн шатахууныг анхан шатны баримтгүй зарцуулсан.
- Бууцагаан сумын ЗДТГ нь тээвэр шатахууны өглөг 1.4 сая төгрөгийн өр үүсгэн төсөвт зардлыг хэтрүүлэн зарцуулсан.
- Галуут сумын ЗДТГ нь Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.4 сая төгрөгийн шатахуун зарцуулсан ч холбогдох тушаал шийдвэрийг гаргаагүй.

Сум хөгжүүлэх сан:

Сум хөгжүүлэх сангийн дансанд оны эхэнд 3.636,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас тайланд онд зээл, зээлийн хүүгийн орлогоор 2,385.0 сая төгрөгийн орлого оруулахаар батлагдаж гүйцэтгэлээр 1,631.1 сая төгрөгийн сая төгрөгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлж, 673.8 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож, оны эцэст 2,592.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ.

Хүснэгт 26 Сумдын Сум хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Мөнгөн Хөрөнгийн		№	Сумын нэр	Мөнгөн Хөрөнгийн	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл			Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Галуут	53.9	135.2	11	Заг	64.6	85.3
2	Баян-овоо	15.1	92.9	12	Баацагаан	20.2	101.3
3	Эрдэнэцогт	56.3	68.1	13	Бөмбөгөр	183.8	8.0
4	Бууцагаан	3.4	235.3	14	Өлзийт	122.8	55.7
5	Жинст	61.1	67.1	15	Хүрээмарал	11.6	63.9
6	Богд	68.90	100.6	16	Баянбулаг	12.9	86.0
7	Баянлиг	119.7	186.1	17	Шинэжинст	23.8	91.7
8	Баянговь	135.8	165.8	18	Баянцагаан	55.4	114.9
9	Гурванбулаг	37.5	59.3	19	Баян-өндөр	41.5	89.0
10	Жаргалант	61.8	57.5	20	Баянхонгор	471.8	729.1
НИЙТ ДҮН						1,621.9	2,592.8

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Галуут, Баян-Овоо, Баянговь, Шинэжинст сумууд СХС-ийн эхний үлдэгдэлтэй, тайлант онд зээлийн эргэн төлөлтийн орлого орсон байхад хөнгөлөлттэй зээлийг сумын иргэдэд олгож, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжиж ажиллаагүй;
- Баянхонгор сумын СХС-нь тайлант оны жилийн эцэст 101 зээлдэгчийн 325.4 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаагаас 10 зээлдэгчийн 11.4 сая зээлийн үлдэгдэл хугацаа хэтэрсэн байна.
- Баянлиг сумын Сум хөгжүүлэн сангаас 2019 онд зээл авсан 3 зээлдэгчийн 8.8 төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн өртэй, зээлдэгчид зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Мөн 2013 онд СХС-аас зээл авсан зээлдэгч А.Цогтгэрэл зээлийн үлдэгдэл 14,722,010 төгрөг ба сумын Засаг даргын 2020.10.14-ны өдрийн 284 тоот албан бичиг, зээлдэгч Ц.Бийбат зээлийн үлдэгдэл 10,304,344 төгрөг ба сумын Засаг даргын 2021.03.04-ны өдрийн 120 тоот албан бичгээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас зээлийг эргүүлэн татсан боловч дээрх зээлдэгчид тохиролцсон хугацаанд зээлийг эгүүлэн төлөөгүй болно.
- Бөмбөгөр сумын Сум хөгжүүлэн сангаас 2019 онд зээл авсан 4 зээлдэгч, 2020 онд зээл авсан 4 зээлдэгчийн 6.2 төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн өртэй, зээлдэгчид зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй байна.
- Жинст сумын Сум хөгжүүлэх сан нь тайлант хугацаанд 123.8 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн 21.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэл байна. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийн 9.1 сая төгрөг нь шийхийн шийдвэр гарсан 12.5 мянган төгрөг шүүхийн шийдвэр гараагүй байна.

- Баянговь сумын Сум хөгжүүлэх санд 2020.12.31-нээр 135832.1 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж, 2021.01.01-2021.12.20-ний хооронд зээл, зээлийн эргэн төлөлтөөр 29727.7 мянган төгрөг орж, 2021.12.20-ний байдлаар 165359.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ба тус сангаас 2021 онд зээл олгоогүй, олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна. Санхүүгийн тайланд авлагаар бүртгэгдсэн зээлдэгч нарын хувийн хэргийн бүрэлдэхүүн хэсэг хангалтгүй, баримт материал дутуу байна.
- Баянбулаг сумын СХС-ийн зээлдэгчийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл 79.2 сая төгрөг байна.
- Галуут сумын СХС-ын Тайлант оны эцэст 119.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагын үлдэгдэлтэй үүнээс хугацаа хэтэрсэн 5 зээлдэгчтэй холбоотой 32.1 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага байгаа бөгөөд 1 зээлдэгчийн 14.7 сая төгрөг нь 2016 онд шүүхийн шийдвэр гарсан боловч одоо болтол зээлээ төлөөгүй, 1 зээлдэгчийн 6.4 сая төгрөг нь 2020 онд эвлэрлийн гэрээ байгуулсан боловч зээлээ төлөөгүй байна.
- Бууцагаан сумын СХС-ын тайлант оны эхэнд зээл зээлийн хүүгийн 213.0 сая төгрөгийн авлагатай бөгөөд тайлант хугацааны эцэст 135.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс хугацаа хэтэрсэн 55.3 сая төгрөгийн авлага байгаа бөгөөд шүүхэд шилжүүлсэн байна. Авлагын үлдэгдэлд 4.7 сая төгрөгийн нас барсан 2 зээлдэгчийн үлдэгдэл байна.
- Заг сумын СХС-ын тайлант оны эцэст 107.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 6.7 сая төгрөгийн авлага байна. Хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэлд нас барсан зээлдэгчийн 7.0 сая төгрөг байна.

ТЭЗ-ын харьяа ТШЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар СХС-тай холбоотой 203.8 сая төгрөгийн алдаа зөрчил илсэнд 119.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 59.9 сая төгрөгийн зөвлөмжийг өгсөн байна.

Цаашид 2017 оноос өмнөх хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн авлагын үлдэгдэлтэй нас барсан иргэдийн зээлийг хэрхэн шийдвэрлэх талаар аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс тодорхой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Хөрөнгийн зардал:

Тус зардлыг өмнөх оны гүйцэтгэлээс 2,845.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 9,737.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 7,543.3 сая төгрөгийн санхүүжилт олгож, 2,845.6 сая төгрөгийн зардал хэмнэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн орон нутгийн төсөө, орон нутгийн хөгжлийн сангаас улсын төсвийн байгууллагуудад нийт 198.6 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч өгсөн байна.
- Энэ Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтыг зөрчиж орон нутгийн төсөвт хүндрэл учруулж байна.
- Цаашид орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө худалдан авч өгдөг зөрчлийг арилгаж төсвийг хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Орон нутгийн хөгжлийн сан:

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд улсын төсвөөс Баянхонгор аймагт олгох орлогын шилжүүлгийг 7,781.6 сая төгрөг, үүнээс аймгийн ОНХС-д 4284.3 сая, сумдын ОНХС-д 2861.9 сая, урсгал зардалд 635.4 сая төгрөг олгохоор баталсан ба энэ хуулийн 2021.07.07 өдрийн нэмэлт өөрчлөлтөөр 310.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 8,091.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор хуульчилсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ны өдрийн 2/9 дугаар тогтоолоор улсын төсвөөс аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 4284.3 сая, сумдын ОНХС-д олгох шилжүүлгийг 2,861,9 сая, орон нутгийн төсвөөс 105.0 сая, хандивын орлогоор 577.2 сая оруулж эх үүсвэрийг оруулахаар, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шилжих 28 төсөл арга хэмжээнд 2,146.0 сая, шинээр хэрэгжүүлэх 7 төсөл арга хэмжээнд 940.5 сая, тоног төхөөрөмж 490.0 сая, бусад арга хэмжээнд 1,390.0 сая нийт 4,966.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.07.21-ны өдрийн 4/15 дугаар тогтоолоор улсын төсвөөс аймагт олгох орлогын шилжүүлгийг 310.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 8,091.9 сая төгрөг болсонтой холбоотойгоор аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг 5,671.7 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ИТХ-ын тогтоол гараагүйгээс төгрөгийн Баянговь, Өлзийт, Эрдэнэцогт сумын 360.7 сая төгрөгийн багийн төвийн барилга, Эрдэнэцогт суманд нийлүүлэгдсэн хог тээврийн автомашиныг нягтлан бодох бүртгэлд орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4."Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2" Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" зөрчсөн байна.

Иймд дээрх хөрөнгүүдэд аймгийн ИТХ-аас эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж, хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого авах зөвлөмжийг аймгийн СТСХ-ийн даргад хүргүүлэв.

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг аймгийн ОНХС-аас гаргаж авлагаар бүртгэсэн ба тус авлагад тухайн төсөл арга хэмжээ нь хэрэгжиж дууссан байхад өмнөх оны авлагын үлдээгдэл 194.3 сая төгрөгийг барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна. Энэ талаар аймгийн ХОХТБХ, СТСХ-ийн холбогдох мэргэжилтнүүдээс тайлбар тодруулга авахад ихэнхи авлага нь тухайн төсөл арга хэмжээний төсөвт зураг төсвийн үнэ суугдаагүй шалтгаанаар авлага барагдахгүй байгаа тайлбарыг ирүүлсэн болно.

- Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; хэсгийг зөрчсөн байна.

Иймд дээрх авлагын үлдээгдэлд бүртгэлтэй төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн даргад зөвлөмжөөр хүргүүлж байна.

Аймаг, сумдын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2021 онд 10,271.6 сая төгрөгийн 334 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 234 ажлыг бүрэн, 46 ажлыг дутуу хэрэгжүүлж, 7,543.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Төлөвлөсөн ажлаас 1487.4 сая төгрөгийн 54 ажил огт хэрэгжээгүй төсвөөс санхүүжилт олгоогүй байна.

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Баянхонгор сумын ОНХС нь "Хогийн цэгийг дарж булшлах" төсөл арга хэмжээнд 50.0 сая төгрөг батлагдаж харьцуулалтын аргаар тендер зарлаж "Номгон такс констракшн" ХХК шалгарч гэрээг 2021.06.07-ны өдөр байгуулж 2021.07.30-ны өдөр дуусгахаар хийсэн байна. Ажлыг бүрэн гүйцэтгэж хүлээлгэн өгсөн харин гэрээнд хяналтын зардал, магадалшгүй ажлын зардлыг тодорхой тусгаагүй байна.
- Бөмбөгөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр Улаан омгийн ямааны үүлдэр болгох ажил төсөл арга хэмжээний хүрээнд Ямаа ангилалтаар ажилласан ажилчдад олгосон урамшуулал 1800.0 мянга,

малын тэжээл 0.4 сая, эм тарианы зардалд 140.0 нийт 2.4 сая төгрөгөөс ХХОАТ суутган тооцоогүй олгосон байна.

- Гурванбулаг сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд тусгагдсан 129.0 сая төгрөгийн малжуулахын авлагын үлдэгдэл байгаагаас 10 хүний 14.6 сая төгрөгийн авлага нь 2013-2017 онд үүссэн гэрээний хугацаа дууссан байна.
- Баянцагаан сумын ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан тээврийн хэрэгслийн гэрчилгээ байгууллагад шилжүүлээгүй байна.
- Хүрээмарал сумын ОНХС-ийн санхүүгийн тайланд 2017-2018 онд олгосон малжуулахын зээлийн авлагч 76.2 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь гэрээний хугацаа дууссан 1.5 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр 17.9 сая төгрөгийн өвс тэжээл худалдан авсан боловч өвс тэжээлийн тооцоо бодож баталгаажуулаагүй, өвс тэжээлээс тайлант онд 0.4 сая төгрөгийн орлого орсон байна.
- Баянговь сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ажлын хэсэг байгуулан хүлээн авч сумын ИТХ-аар эзэмшигчийг тогтоолгон 116.0 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.
- Хүрээмарал сум нь сумын ИТХ-ын хурлын тогтоолоор "Бүх төрлийн өвс тэжээл худалдан авах" арга хэмжээний зардалд 10.0 сая төгрөг баталж өгсөн байхад гүйцэтгэлээр 14.9 сая төгрөг зарцуулж батлагдсан төсвийг 4.9 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Сумын ИТХ-ын хурлын тогтоолоор баталсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Сум дундын Ойн ангид өгөх 17.4 сая төгрөгийн өвс тэжээлийн өглөгийг баталж өгөөгүй байхад 2021.06.21-д санхүүжилтийг шилжүүлсэн.
- Гурванбулаг сумын ОНХС-ийн Эрчим хүчний шугамын өргөтгөл хийх ажлын хэрэгжүүлэхдээ гүйцэтгэгчээс магадалшегүй ажлын зардал 0.3 сая төгрөгийг суутган тооцоогүй байна. Мөн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн гамшигаас хамгаалах өвс худалдан авах, оготно устгах ажилтай холбоотой бэлтгэсэн 7.5 сая төгрөгийн хөрөнгийг ЗДТГ-т орлого аваагүй байна. ОНХС-ийн санхүүгийн тайланд 0.6 сая төгрөгийн өвс тэжээлийн авлага байгаа нь 2018-2019 онд үүссэн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Тайлант хугацааны ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХС-аас авах санхүүжилт 96.8 сая, урьд оны үлдэгдлээс 3.1 сая, орон нутгийн төсвөөс 35.0 сая төгрөгөөр бүрдүүлж зарцуулахаар баталсан ба тайлант хугацаанд гүйцэтгэлээр төвлөрсөн өвс тэжээлийн 8.6 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Жаргалант сумын ОНХС-ийн тайлант хугацааны ОНХС-ийн эх үүсвэрийг ОНХС-аас авах санхүүжилт 101487.2 мянга, урьд оны үлдэгдлээс 26359.5 мянга, орон нутгийн төсвөөс 10000.0 мянга, өвс тэжээлийн орлогоор 17455.3 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж зарцуулахаар баталсан ба тайлант хугацаанд өвс тэжээлийн давсан орлого 2021.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Баян-Овоо сумын ОНХС-ийн өмнөх онд Ган утас мөнх ХХК-аас 0.3 сая төгрөгийг илүү төлж авлага үүссэн байгааг барагдуулаагүй байна. Шинэ өлгийн зам ХХК-тай гэрээ байгуулан эмийн байрны засварын ажлыг гүйцэтгүүлэхээр 2021.09.10-д 17.0 сая төгрөгийг шилжүүлэн ажлыг бүрэн хийгээгүй авлагаар тусгасан байна.
- Жинст сум "Хонгорын шугуй" ХХК-тай нийтийн био нойл хийх 10.0 сая төгрөгийн ажлын гэрээг сумын Засаг дарга Р.Батжаргалтай 2021.11.22-ний өдөр байгуулж, 45 хонгийн дотор гүйцэтгэж, урьдчилгааг 100% олгохоор гэрээ байгуулжээ Аудитаар газар дээр нь ажлыг шалгахад ажил эхлээгүй байна. Мөн Сумын ИТХ-ын 2021.11.15-ны өдрийн хуралдаанаас тодотголоор Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө үйл ажиллагаанд 14.0 сая төгрөгийн төсөв баталсан боловч зарцуулалтаар энэхүү ажиллагаанд 17.3 сая төгрөгийн зарцуулалт хийсэн нь батлагдсан төсвийг 3.3 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 6.4.4 т заасан 36.8 сая төгрөгийн 2 мэдээллийг хоцроож мэдээлсэн байна.

ТЕЗ-ийн ТШЗ-чид хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой 807.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 11.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 129.6 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 666.7 сая төгрөгийн алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Замын сан:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ны өдрийн 2/9 дугаар тогтоолоор АТБӨЯХАТ-ыг 580.0 сая, орон нутгийн авто зам ашигласны төлбөр 240.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталж, аймгийн ИТХ-ын 2021.06.29-ний өдрийн 3/10

тогтоолоор өмнөх оны үлдэгдэл 12.1 сая, 2020 оны давсан орлого 120.6 сая төгрөгийг нэмж тодотгон нийт 947.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Аймгийн автозамын сангийн хөрөнгөөр 2021 онд өмнөх оноос шилжих 3 төсөл, арга хэмжээнд 296.2 сая, 2021 онд шинээр хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээнд 651.5 сая төгрөг олгохоор тус тус төлөвлөжээ.

Замын сангийн харилцах дансанд оны эхэнд 12.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба АТБӨЯХАТ-аар 605.2 сая, авто зам ашигласны хураамжийн орлогоор 297.4 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, орон нутгийн орлогоос нийт 935.6 сая төгрөгийн санхүүжилт авч 12 батлагдсан төсөл, арга хэмжээнд 904.3 сая төгрөгийн зардал гаргаж 43.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Шинэ суурьшлын бүсийн 8,5 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын барилгын ажлын зураг төсвийн үнэнд 50.0 сая төгрөгийг аймгийн ИТХ-ын 2021.06.29-ны өдрийн 3/10 тогтоолоор баталсан ба аймгийн Засаг даргын 2021.12.13-ны өдрийн А/749 дугаар захирамжаар “Шинэ суурьшлын бүсийн автозамын барилгын үерийн усны шуудууны ажлын зураг төсөв” 15.0 сая төгрөгийн ажлын нэмж 53.9 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 16.5.5. “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд төсөл арга хэмжээний төлөвлөлтийг бодитой хийж батлагдсан төсвийн хүрээнд төсвийг удирдан зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна .

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал:

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний өдрийн 2/9 дугаар тогтоолоор аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 41 хөтөлбөр, арга хэмжээнд 1,100.0 сая төгрөг баталсан ба тайлант онд 3 удаагийн захирамжаар 50 төсөл арга хэмжээнд 331.3 сая төгрөгийг нэмж 1431.3 сая төгрөгөөр баталсан ба аймгийн Засаг даргын 2021.12.06 өдрийн А/742 дугаар захирамжаар төсөвт зохицуулалт хийж хэрэгжээгүй болон хэмнэгдсэн зардлаас 165.7 сая төгрөгөөр бууруулан 1305.6 сая төгрөгийн 50 төсөл арга хэмжээг батлан, нийт 1,295.8 сая төгрөгийг зарцуулж 9.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг даргын 2021.12.06 өдрийн А/742 дугаар захирамжаар төсөвт зохицуулалт хийж аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.07.21-ний өдрийн 4/15 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан жагсаалтад байхгүй аймгийн Прокурорын газрын албан хэрэгцээнд шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 20.0 сая, Өлзийт сумын постын цахилгааны зардал 8.4 сая төгрөгийг олгосон байна.

- Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021.07.21-ний өдрийн 4/15 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан жагсаалтад Шүүхийн шинжилгээний албаны автомашин худалдан авахад 36.0 сая баталсан байхад 39.7 сая, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах, хөгжил хамгааллыг сайжруулах, хүртээмжтэй эзлтэй орчин бүрдүүлэхэд 100.0 сая төгрөг батласан байхад 100.4 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2021 оны А/629, А/742 дугаар захирамжаар төсөвт зохицуулалт хийж олгосон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹¹, 16.5.5¹², 42 дугаар зүйлийн 42.7¹³ дахь заалтыг тус тус зөрчсөн байна. Иймд төсөл арга хэмжээний төлөвлөлтийг бодитой хийж батлагдсан төсвийн хүрээнд төсвийг удирдан зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалтын данс

Төрийн сан дахь 100030051350 тоот Бх.Барьцаа хөрөнгө оруулалт дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 2,076.4 сая төгрөг, тайлант хугацаанд 5,678.0 сая төгрөгийн орлого төвлөрч, 1632.2 сая төгрөгийн зарцуулалт гарч, оны эцсийн үлдэгдэл 6,212.2 сая төгрөг байна.

Барьцаа хөрөнгийн дансанд УТХО, аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 24 төсөл арга хэмжээний 5.654.0 сая төгрөг төвлөрснөөс чанарын баталгаа 709.6 сая, дуусаагүй 10 ажлын 4,944.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт№27. Барьцаа хөрөнгө оруулалтын дансны орлого, зарлагын гүйлгээ

Д.Д	Хөрөнгө оруулалтын ажлын нэр	Байршуулсан дүн	Үүнээс: Чанарын баталгаа	Дуусаагүй ажлын санхүүжилт
1	УТХО-аар хэрэгжсэн ТАХ	5,457.6	607.1	4,850.5
2	Бусад эх үүсвэрээр хэрэгжсэн ТАХ	196.4	102.4	94.0
	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	5,654.0	709.6	4,944.5

Барьцаа хөрөнгийн данснаас буцаан олгосон чанарын баталгааны мөнгө 1,237.4 сая, техник хяналтын зардал 105.5 сая, нормчлолын зардал 0.8 сая, зураг төсөв, зохиогчийн хяналтын зардал 27.2 сая УТХО-ын буцаан олгосон санхүүжилт 47.4 сая, эргэн төлөгдөх нөхцөлөөр бусдад олгосон төлбөр 100.0 сая нийт 1,518.2 сая төгрөг зарцуулжээ.

Төрийн сан дахь 100030051370 тоот Бх.Техник хяналт зардлын дансанд оны эхэнд 428.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд 1,248.1 сая төгрөг төвлөрч, 1,147.9 сая зарцуулалт гарч оны эцэст 528.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.06.04 -ны өдрийн 131/ШШ2020/00702/ тоот шийдвэрийг үндэслэл болгон Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020.07.30-ны өдрийн 131/ГХ2020/00424 дугаартай шүүхийн гүйцэтгэх баримт бичгээр Д.Алтангэрэлд 2019.07.09-2020.4.06-ны хүртэлх ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговорт 9.8 сая төгрөг, НДШ, ЭМД хуульд заасан хэмжээгээр зохих санд нөхөн төлөх шийдвэр гарсан байна. Дээр Шүүхийн гүйцэтгэх баримт бичгийн дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2021.01.14-ны өдрийн А/41 дугаар захирамжаар Төрийн сангийн техник хяналтын 100030051370 харилцах данснаас 2021.04.09-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 230000037952 тоот харилцах дансанд 6.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн ту аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албан шаардлага хүргүүлэв.

¹¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹² батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹³ 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой:

Тайлант онд Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор аймгийн онцгой комисс болон төрийн болон орон нутгийн өмчит төсөвт байгууллагуудад нийт 51,427.9 сая төгрөгийг улс болон орон нутгийн төсөв олон улсын төсөл хөтөлбөрөөс санхүүжүүлсэн бол иргэд, аж ахуйн нэгжүүдээс 1,295.9 сая төгрөг болон 16,927.4 сая төгрөгийн үнэ бүхий хөрөнгө материалыг хандивласан байна.

Хүснэгт 28. Ковид-19 цар тахалтай холбоотой орлогын судалгаа:

Орлогын төрөл	Аймгийн онцгой комисс	Улсын төсвийн байгууллага	Орон нутгийн төсвийн байгууллага	ТБОНӨААН	Нийт орлогын дүн	
Улсын төсвөөс санхүүжсэн	-	49,953.0	197.3	1,028.8	51,179.1	
Орон нутгийн төсвөөс санхүүжсэн	-	14.7	92.1	50.4	157.3	
Засгийн газрын нөөц хөрөнгө	-	-	4.4	-	4.4	
Олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж	-	80.8	6.4	-	87.2	
Тусламж санхүүжилтийн орлого		50,048.5	300.2	1,079.2	51,427.9	
хандив:						
Үүнээс	Бэлэн мөнгө	1,125.0	0.8	170.1	-	1,295.9
	Бараа	236	571	337	2	1,146
	материал	138.6	2,936.4	13,359.3	8.5	16,442.8
	Мөнгөн дүн	-	0	1	0	1
	Үндсэн хөрөнгө	-	255.1	228.7	1.3	485.2
	Мөнгөн дүн	-	-	-	-	-

Баянхонгор аймагт коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбоотой 2021 онд аймгийн онцгой комисс болон төрийн болон орон нутгийн өмчит төсөвт байгууллагууд нийт 12,371.5 сая төгрөг зарцуулснаас 276.2 сая төгрөгийн хөрөнгийн зардалд, 12,095.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан ба үүнээс 3,700.2 сая төгрөгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлд, 446.0 сая төгрөгийг хангамж бараа материалын зардалд, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, ормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардалд 4,297.2 сая, эд хогшил урсгал засварын зардалд 325.9 сая, бараа ажил, үйлчилгээний бусад зардалд 2,051.0 сая, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 1,244.7 сая төгрөг зарцуулсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн Засаг даргын 2021.08.06-ний өдрийн А/490 дүгээр захирамжаар аймгийн Нэгдсэн эмнэлэгт 32.6 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн зориулалттай угаалгын машин авахаар "Ай мед техноложис" ХХК-тай гэрээг 2021.06.30-ны өдөр байгуулж, гэрээний 3.1-т тоног төхөөрөмжийг 2021.07.30-ний дотор багтаан хүлээлгэн өгөхөөр заасан ба 2021.07.25-ний өдөр Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа Э.Батбаяр хүлээн авсан тухай актыг үйлдэж, 2021.08.05-ний өдөр мөнгийг шилжүүлсэн боловч тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй тул зөрчлийг арилгах албан шаардлагыг аймгийн ОБГ-т хүргүүлэв.
- Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан аймгийн Онцгой байдлын шийдвэрээр 2021 онд төсөвт байгууллага, эмийн сангуудад урьдчилан сэргийлэх болон эмчилгээний багц олгож, 9.0 сая төгрөгийн багцын үнийг буцаан төлүүлээгүй атлаа санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй тул буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.
- Баянхонгор аймгийн Барьцаа хөрөнгийн данснаас 2021 онд "Мандал баян булаг" ХХК, "Их ган зүү" ХХК-д тус бүр 50.0 сая төгрөгийг Коронавируст халдварын эсрэг цогц тусламж үйлчилгээний хүрээнд Эрдэнэ мандал ахлах сургуулийн дотуур байранд 130 ор дэлгэж хэвтэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсний урьдчилгаа санхүүжилтэд аймгийн онцгой комиссын 2021.09.04-ний өдрийн 61 дүгээр хуралдааны шийдвэрээр ЭМД-ийн сангаас санхүүжилт орж ирэхэд буцаан авахаар олгосон, техник хяналтын данснаас "Мед импекс интернэшнл" ХХК-д 30.0 сая төгрөгийн ковидын тестийн

үнэ шилжүүлсэн тул аймгийн ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 3 байгууллага 110.8 сая, Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 10 байгууллага 157.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 118 байгууллага 4,258.9 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 50 байгууллага 2,566.3 сая, нийт 138 байгууллага 9,588.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.



Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 114 байгууллага 6,860.7 сая, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулалд 1 байгууллага 3.8 сая, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардалд 2 байгууллага 152.0 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгө тэтгэмжид 25 байгууллага 815.2 сая, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгт 58 байгууллага 1,128.7 сая, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардалд 3 байгууллага 117.2 сая, хөрөнгийн зардалд 3 байгууллага 15.6 сая нийт 9,093.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 495.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад нийт 1,128.7 сая төгрөг олгосныг байгууллагын төрлөөр нь авч үзвэл эрүүл мэндийн салбарын албан хаагчдад 377.6 сая, ерөнхий боловсролын сургуулийн албан хаагчдад 550.9 сая, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын албан хаагчдад 200.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн харьяа ТШЗ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төвлөрсөн мөнгийг зарцуулахдаа холбогдох шийдвэрийг гаргуулаагүй, анхан шатны баримтыг бүрдэл дутуу, зарим гүйлгээг үндсэн дансаар дамжуулан олгосон зэргээр Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмыг хэрэгжүүлээгүйгээс 11 байгууллагад 109.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

ТЗШ-ийн СТА-аар тус зардалтай холбоотой илэрсэн зөрчлүүд:

- Баян-Өндөр сумын ЗДТГ нь өөрийн орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр спорт заалны орлого, тендерийн баримт бичгийн үнэ, ухаалаг худгийн картын үнэ зэрэг орлого орсон ч өөрийн орлогоор тайлагнаагүй нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан.
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь нэмэлт санхүүжилтийн данснаас үндсэн дансруу зөвшөөрөлгүй 3.0 сая төгрөгийг шилжүүлсэн бөгөөд үндсэн данснаас хуванцар хогийн сав хийлгэсэн компани руу гэрээний үлдэгдэл төлбөр болох 3.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн ч санхүүгийн тайланд бүртгээгүй байна. Мөн үндсэн дансруу орсон 3.0 сая төгрөгийн орлогыг бүртгээгүй, байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас 30191.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансруу шилжүүлж, тайлант хугацааны зардлаар тайлагнасан.
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар тэтгэвэр тогтоолгосон ажилтны тэтгэмж болох 21,124.8 мянган төгрөг тус байгууллагын нэмэлт дансанд орсон ч уг ажилтны хүүхэд 6 нас хүрээгүй гэсэн шалтгаанаар тэтгэмж олгогдоогүй буцаан төвлөрүүлж, авлагаар тусгасан.
- Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 28.2 сая төгрөг төвлөрүүлсэн бөгөөд тус орлогыг зарцуулахад Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалыг хэрэгжүүлээгүй, 28,219.0 мянган төгрөгийг зарцуулсан, үүнээс 1.7 сая төгрөгийн өвс тэжээлийн үнийг сум дундын Ойн ангид шилжүүлсэн, нэмэлт санхүүжилтийн дансны гүйлгээтэй холбоотой шийдвэр, анхан шатны баримтыг аудитаар шалгуулаагүй болно.
- Аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн “Төсөвт байгууллагын нэмэлт орлогыг зарцуулах тухай” А/438 дугаартай захирамжаар төсөвт байгууллагуудын нэмэлт орлогыг зарцуулах хуваарийг хавсралтаар батлаагүй байхад дээрх шийдвэрийг үндэслэн Эрдэнэцогт сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 онд үйлчилгээний орлогыг төлөвлөөгүй атлаа байгууллагын үйл ажиллагаагаа явуулан гүйцэтгэлээр 6,387.9 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансандаа төвлөрүүлж зарцуулсан.
- Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн “Гадна тохижилт хийх тухай” 204 тоот албан бичгээр барилга, угсралтын кампаниудад шаардлага хүргүүлж хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг даалгасан байна. Тус албан бичгийн дагуу өөрийн гүйцэтгэлээр барьсан орон сууцны гадна тохижилтын ажлыг хийж гүйцэтгээгүй Зоригтболд ХХК-аас 7.5 сая, иргэн А.Баасандоржоос 7.5 сая, С.Ганбатаас 7.0 сая нийт 22,000.0 мянган төгрөгийн хүү торгуулийн орлогыг Баянхонгор сумын нэмэлт санхүүжилтийн Төрийн сан банк дахь 10032055405 тоот дансанд төвлөрүүлэн Номгон 1-р баг, Рашаант 10-р багуудад хийгдсэн тоглоомын талбайн тохижилтыг санхүүжүүлж орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлээгүй зориулалт бусаар зарцуулсан
- Богд сумын ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар 2.8 сая төгрөгийн давсны орлогыг төвлөрүүлэн зарцуулсан.
- Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургууль нэмэлт санхүүжилт дансанд өөрийн орлогоор 1.0 сая төгрөгийг төвлөрүүлж зөвшөөрөлгүй бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан.

Иймд Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Бүлэг 3. Сумдын ТТЗ-ийн нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг сумын ИТХ-аар батлуулж тайлагнаагүй, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2020.12.04-ний хуралдааны өдрийн 2/9 дугаар тогтоолын нэг дүгээр хавсралтаар “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт” ийг 13 хөтөлбөрийн 70105, 70106, 71101, 70426, 71413, 71403, 72208, 71902, 71502, 71702, 71509, 72207, 71602 53 арга хэмжээг 82,479.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталж, хэрэгжилтийг Баянхонгор аймаг дахь ТАГ-т 2022.04.01-ны өдрийн 1а/181 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын даргын Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрт 5 арга хэмжээнд 9 зорилт дэвшүүлж биелэлтийг тооцсон байна. Тухайлбал: Аймгийн ИТХ-ын ээлжит болон ээлжит бус хуралдаан 5 удаа хуралдаж, 27 тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаан 22 удаа хуралдаж, 135 тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн ИТХ 7 хороотойгоор ажилласан бөгөөд хороод нийт 15 удаа хуралдаж, 53 асуудлыг хэлэлцэж, 25 санал дүгнэлт гарган аймгийн ИТХ, Тэргүүлэгчдэд саналаа дүгнэлтээ оруулж хэлэлцүүлсэн.

Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 14 хөтөлбөр хэрэгжүүлэхээр 48 арга хэмжээний хүрээнд 73 зорилт дэвшүүлж биелэлтийг тайлагнасан байна. Тухайлбал:

Баянхонгор аймгийн 7274 ахмад настанд төрийн үйлчилгээ, мэдээллийг хүргэж ажиллахад 118.1 сая төгрөг зарцуулсан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 7 ажил арга хэмжээнд зарцуулахаас усны нөөц, зураглал хийж, бохирдлоос хамгаалах, мэдээллийн сан бүрдүүлэхэд 3 ажлын 32.0 сая, орчны бохирдол бууруулах бодлогын хүрээнд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулахад 40 сая, Биологийн төрөл зүйлийг хамгаалах бодлогын хүрээнд 10 сая, ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах 10.0 сая төгрөгийн ажил хэрэгжүүлсэн, 2021-2022 оны хичээлийн жилийн жилд төрийн болон төрийн бус өмчийн 32 сургуульд 18496 суралцагч хамруулж бага боловсролын хамран сургалт 98,1 хувь, суурь боловсролын хамран сургалт 95,9, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 90 хувь, дотуур байранд амьдрах хүсэлтээ гаргасан сурагчдын 99,1 хувь дотуур байранд хамруулсан, сургуулийн өмнөх боловсролд 5780 хүүхэд буюу 97.7 хувьтай хамруулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар

Баянхонгор аймгийн СТСХ-ээс аймгийн ЗДТГ-ын 2020.12.08-ны өдрийн 7/1589 дугаар “Сумдын Засаг дарга нарт” албан бичгээр сумын 2021 оны төсвийн төсөл боловсруулж сумын ИТХ-аар батлуулахад анхаарах чиглэлийн дагуу Баян-Овоо, Баянлиг, Баянцагаан, Баацагаан, Бууцагаан, Заг, Баян-Өндөр, Гурванбулаг, Өлзийт, Хүрээмарал сумд нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр сумын ИТХ-ын тогтоолоор баталсан боловч бүх сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь хэсэгт заасан бүрэлдэхүүн хэсгээр гаргаж тайлбар танилцуулгын хамт Баянхонгор аймаг дахь ТАГ-т ирүүлээгүй байна.

“Цаашид Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.2-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх” зөвлөмжийг бүх сумын Засаг даргад хүргүүлэв.

Мөн аймгийн Засаг даргын 2021.12.06-ний өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/742 дугаар захирамжаар сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт төсөвт өөрчлөлт

оруулсан байхад 15 сумын ИТХ-аар 295.3 сая төгрөгийн тусгай шилжүүлгийн санхүүжилтийн өөрчлөлтийг батлаагүй байна.

Иймд “Сумын Засаг дарга дээд шатны төсөв захирагчаас төсөвт өөрчлөлт оруулсан тохиолдолд төсвийн тодотголыг боловсруулж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж төсөвт тодотгол хийлгэж байх зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.

3.2 АЙМГИЙН САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТЭС ӨМНӨХ ОНЫ АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАЖ АЖИЛЛАСАН Ч ЗӨРЧЛҮҮД БҮРЭН АРИЛААГҮЙ БАЙНА.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2¹⁴ дахь заалтын дагуу өмнөх аудитын зөвлөмжийн хариуг 2021.08.26-ний өдрийн 7/1283 дугаар албан бичгээр гаргаж ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны аудитаар гарсан алдаа зөрчилтэй харьцуулан үнэлэхэд зөвлөмжийн биелэлт 83.3 хувьтай үнэлэгдэж байна.

Хүснэгт 29. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
Нэг. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч Д.Мөнхсайхан танаа			
1	Сум хөгжүүлэх сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг төлүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Сумдын засаг дарга, Хүнс хөдөө аж ахуйн газар, ХОХБТ-ын хэлтэст Сум хөгжүүлэх сангаас олгосон хугацаа хэтэрсэн зээл, насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээг авч ажиллах талаар СТСХ-ын даргын 2021.05.19-ны өдрийн 7/722, 7/723, 7/724 дугаар албан бичгүүдээр чиглэл хүргүүлсэн байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Сум хөгжүүлэх сангийн өмнөх оны зээлийн авлага 3,636.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 2,671.8 мянган төгрөг болж 965.0 сая төгрөгөөр буурснаас үзэхэд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100%
2	Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гарч байгаа ажилтнуудад хоолны зардлыг олгох талаар нэгдсэн шийдвэр гаргаж, Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Засгийн газрын 2021.02.17-ний өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах. 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.
		Аудитаар тооцсон биелэлт	Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нийт батлагдсан төсөв 96,047.2 сая төгрөг ба гүйцэтгэлээр 89,196.8 сая төгрөг зарцуулж төсөвт 7.1 хувийн хэмнэлт гаргасан Биелэлт 70%
3	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх “Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх” заалтыг хэрэгжүүлж, сумдын Эрүүл мэндийн төвөөс төсвийн төслийг хүлээн авах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх “Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх” заалтыг хэрэгжүүлж, сумдын Эрүүл мэндийн төвөөс төсвийн төслийг нэгтгэн хүргүүлсэн байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100%

¹⁴ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.

№	Өгсөн зөвлөмж	Байгууллагаас ирүүлсэн албан бичгийн утга, биелэлт	
4	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2013 оны А/97 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 2.1.10-т заасны дагуу асруулагчийн тэтгэврийн 30 хувийг аймгийн Асрамжийн газрын төсвийн бүрэлдэхүүнд оруулж батлах.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Аймгийн Асрамжийн газрын 2022 оны төсвийн төсөлд асруулагчийн тэтгэврийн 30 хувиар тооцон өөрийн орлогын төлөвлөгөөг батлах болно.
		Аудитаар тооцсон биелэлт	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 %
5	Байгууллага, сангийн анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайланд тавих сумдын санхүүгийн албаны дарга нарын үүрэг оролцоог нэмэгдүүлж, сангийн яамны Э-тайланд 2021 оны эхний хагас жилийн тайланд өмнөх оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар зөв оруулсан эсэхэд аймгийн СТСХ-ээс хяналт тавих.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Сумдын санхүүгийн албаны ажиллах боловсон хүчин, хүний нөөцөд асуудал үүсэж байна. Зөвхөн санхүүгийн албаны дарга, төлбөр тооцооны мэргэжилтэн гэсэн албан тушаалын хувьд 2021 оны 8 дугаар сарын байдлаар 13 сумын 16 ажлын байранд төрийн албаны шалгалт өгөөгүй, шинэ хүмүүс Коронавируст халдварын тухай хуулийн дагуу түр томилогдон ажиллаж байна. Энэ мэт боловсон хүчний асуудал үүссэн нь Төрийн сангийн төлбөр тооцооны хувьд асуудал үүсэж байна.
		Аудитаар тооцсон биелэлт	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100 %
Хоёр. Аймгийн ЗДТГ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ж.Алтанцэцэг танаа			
6	Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.6 дахь заалтыг хэрэгжүүлж, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтээр бэлтгэж, жилийн эцэст гарсан үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулж, дүн шинжилгээ хийж, аймгийн хэмжээнд нэгтгэн Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4-т заасны дагуу аймгийн Төрийн аудитын газарт 2022.04.01-ний дотор ирүүлэх.	Байгууллагаас ирүүлсэн тайлбар	Сумдын санхүү, албаны дарга нарт төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнг тоо болон чанарын үзүүлэлтийг гаргах зааврыг боловсруулан хүргүүлсэн.
		Аудитаар тооцсон биелэлт	Зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Биелэлт 100%
БИЕЛЭЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ 95.0%			

Эх сурвалж: Аймгийн СТСХ-ийн 2021.08.26-ний өдрийн 7/1283 дугаар албан бичиг

Аудитаар нийт 4,314.9 сая төгрөгийн зөрчил илэрснээс 9.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, 4,267.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 9 зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төлөвлөсөн орон нутгийн орлогын төлөвлөгөөг 125.0 хувиар биелүүлсэн ч аж ахуйн нэгжүүдээс “Орон нутгийн хамтын ажиллагааны” гэрээний 3,361.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.
2. Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2021 оны батлагдсан төсөвт аймгийн Засаг даргын захирамжаар урсгал үйл ажиллагааны зардлаас 1765.9 сая төгрөгийн хөрөнгө материалын шинжтэй зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 42.7 дахь заалттай нийцэхгүй байна.
3. ТЕЗ-ийн батлагдсан төсвийг Ковид-19 цар тахал, малын гоц халдварт өвчин гарсан, ЕБС-ийн урамшууллын зардлыг орон нутагт шилжүүлсэнтэй холбоотойгоор төсвийн жилийн дундуур тодотгол хийж төлөвлөгөөг 5.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
4. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан ч зөрчлүүд бүрэн арилаагүй, давтагдан гарсаар байна.
5. Сумдын ТТЗ-ийн нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлтийг сумын ИТХ-аар батлуулж тайлагнаагүй, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.
6. Тайлант онд 3 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж байгуулагдсаны 2 нь аудитад хамрагдаагүй бөгөөд зарим нь чиг үүргээсээ өөр үйл ажиллагаа явуулсан зөрчил илэрч сөрөг дүгнэлт авсан байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн доорх албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. ИТХ-д толилуулах нь:

1. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ажлын үр дүн, төлөөлөн удирдах зөвлөлийн баталж байгаа үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ИТХ-ын Хуралдаанаар авч хэлэлцэн менежментийн асуудалд анхаарал хандуулж шийдвэр гаргах.
2. Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг сүүлийн жилүүдэд сумдад байгуулж эхэлж байгаа нь орон нутгийн төсөвт орох орлого хяналтгүйгээр зарцуулагдах эрсдэл үүсэж байгаа тул зарим аж ахуйн нэгжид хяналт, шалгалт хийж татан буулгах, статусыг нь өөрчлөх саналтай байна.

Нэг. Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан танаа

1. Уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчид аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу төвлөрөх орлогыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 17 дугаар зүйлд заасны дагуу “Орон нутгийн сан” -д төвлөрүүлэн зарцуулж байх.
2. Монгол улсын 2022 оны “төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 388 дугаар тогтоолыг хэрэгжүүлж нэн шаардлагатай тоног төхөөрөмж, аж ахуйн материалын жагсаалтыг гарган хэрэгцээ шаардлагаар нь эрэмбэлэн төсвийн төсөлдөө тусган хүргүүлж, батлагдаагүй зардлыг төсөвт зохицуулалт хийлгэн санхүүжүүлэхгүй байх.
3. Орон нутгийн төсвөөс улсын төсвийн байгууллагуудад хөрөнгө худалдан авч өгдөг зөрчлийг арилгаж төсвийг хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах.
4. Аймгийн ИТХ-аар батлагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг Засаг даргын захирамжаар зохицуулалт хийн санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох.
5. “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ”-ний дагуу аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3,361.4 сая төгрөгийн ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэгч этгээд мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж Орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтаа баталгаажуулсны дараагаар хөрөнгийг хүлээн авч орлогод авах тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

Хоёр. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаа танаа

1. Аймаг сумын ИТХ-аар тодотгон баталсан төсвийн орлого, татварын орлогын өөрчлөлтийг тухай бүр Сангийн яамны Э-тайланд нэгтгэж, орлогын гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх.
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хийгдсэн төсөл, арга хэмжээний зураг төсвийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.
3. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгүүдэд аймгийн ИТХ-аас эзэмшигч тогтоох шийдвэр гаргуулж, хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд орлого авах.

Гурав. Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт

1. Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалттай нийцүүлэн тайлагнаж байх, мөн хуулийн 64.1.3-т заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж батлуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 25-ний дотор, холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн хамт олонд талархал илэрхийлье.

_____оОо_____